

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 59
1.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/</i>	6 – 7
2.	<i>Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт</i>	7 – 31
3.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Нүүрсний цэвэр технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах тухай/</i>	31 – 49
4.	<i>Үйлдвэрлэл технологийн паркийн хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмж</i>	49 – 59

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
06 дугаар сарын 24-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 23 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 52.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 47 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Лувсанжамц, П.Мөнхтулга;

Чөлөөтэй: Д.Батбаяр, Ц.Даваасүрэн, Х.Жангабыл, Д.Жаргалсайхан, Б.Пунсалмаа.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Баярмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга С.Ганбаатар Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Ганбаатар: “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэргэжилтэн Э.Сугарбаяр, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Жижиг, дунд үйлдвэрийн газрын Зээл, төслийн газрын дарга Н.Энхтөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Баярмаа, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Б.Алтан, М.Мандхай нар байлцав.

Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын

хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, Г.Очирбат, Л.Мөнхбаясгалан, Б.Тулга, С.Ганбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, С.Ганбаатар нар үг хэлэв.

С.Ганбаатар: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нүүрсний цэвэр технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Баярмаа нар байлцав.

“Нүүрсний цэвэр технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг төсөл санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Д.Үүрийнтуяа, Б.Тулга, М.Энхцэцэг нарын тавьсан асуултад төсөл санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Д.Үүрийнтуяа, Б.Тулга, Ж.Золжаргал нар үг хэлэв.

С.Ганбаатар: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 12 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Үйлдвэрлэл технологийн паркийн хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмж

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Эрдэнэс үйлдвэр, технологийн парк” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Мөнх-Идэр, мөн компанийн хуульч Н.Баяраа, төслийн менежер

Б.Мягмаржаргал, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн зөвлөлийн зохицуулагч Б.Гэрлээ, Монголын Үйлдвэр, технологийн паркуудын нэгдсэн холбооны Ерөнхийлөгч Р.Батгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Баярмаа нар байлцав.

Үйлдвэрлэл технологийн паркийн хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмж, ажлын хэсгээс боловсруулсан Байнгын хорооны тогтоолын төслийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга, Ж.Золжаргал, С.Ганбаатар, Г.Очирбат, Д.Үүрийнтуяа нар үг хэлэв.

С.Ганбаатар: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 12 минут үргэлжилж, 23 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 69.6 хувийн ирцтэйгээр 12 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 47 минут

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Ганбаатар: Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн ирсэн байна, Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, Болдын Уянга гишүүн ирсэн байна, Дуламын Д.Бум-Очир гишүүн ирсэн байна, Сонгобайн Замира гишүүн ирсэн байна, Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна, Доржзовдын Энхтуяа гишүүн ирсэн байна, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн байна, Сүрэнжавын Лүндэг гишүүн ирсэн байна, Буяагийн Тулга гишүүн ирсэн байна, Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн ирсэн байна.

Ингээд ирц 52.2 хувьтай байна.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Одоо Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал.

Нэгдүгээрт, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

Хоёрдугаарт, Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт байгаа.

Энэ дээр М.Бадамсүрэн гишүүн болон нэлээн олон гишүүд маш идэвхтэй, үр дүнтэй ажилласан байгаа. Хоёрдугаар хэлэлцэх асуудал байна.

Гуравдугаарт, Байнгын хорооны тогтоолын төсөл “Нүүрсний цэвэр технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах тухай”

Та нарт материал танилцуулсан байгаа.

Ж.Золжаргал гишүүн санаачилгатай энэ дээр нэлээн. Хоёр долоо хоног явж байгаа шүү.

Тэгээд энэ дээр Та бүхэн маань танилцаад санаа бодлоо илэрхийлнэ биз дээ.

Дөрөвдүгээрт, Үйлдвэрлэл технологийн паркийн хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмж.

Энэ бол нэлээн чамбай хэлэлцэж боловсрогдсон. Болдын Уянга гишүүн ахалж удирдаж үүнийг зохион байгуулж үр дүнтэй ажлууд явагдаж байгаа. Ийм 4 хэлэлцэх асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Санал байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Энэ бол Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан хүсэлтийн дагуу Аж үйлдвэрлэлийн бодлогын байнгын хорооны 2025 оны 09 дүгээр тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан дээрх мега төслүүдийн хэрэгжилтийн явцыг шалган судлах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, бодлогын дэмжлэг үзүүлэх хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмж оруулах тогтоолын төслийг боловсрууллаа.

Ингээд Ж.Золжаргал гишүүн үндсэндээ Д.Үүрийнтуяа гишүүний ахалсан ажлын хэсэгт оруулж өгөөч гэсэн хүсэлт байгаа.

Үүнийг тэгэхдээ заавал хурлаар шийднэ.

Энэхүү “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд.

Би тогтоолын төслийг уншаад танилцуулъя.

Тогтоолын тогтоолд өөрчлөлт оруулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Аж үйлдвэрлэлийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэрлэлийн бодлогын байнгын хорооны 2025 оны ажлын хэсэг байгуулах тухай 09 дүгээр тогтоолын 1 дэх заалтад тусгагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал гэж нэмсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Нэрээ өгнө үү. Алга байна. Үг хэлэх гишүүд бас нэрээ өгнө үү. Алга байна.

Ингээд асуулт асуух, үг хэлэх гишүүд алга байна. Ингээд санал хураалтад бэлтгэе. Та бүхэн маань хуруугаа уншуулаарай.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

66.7 хувийн саналаар Ж.Золжаргал гишүүн ажлын хэсэгт орлоо.

Ингээд ажлын хэсэг маань идэвхтэй чармайлттай, өмнөх ажлын хэсгүүд шигээ ажиллана гэдэгт би итгэлтэй байна.

Ингээд тогтоолын төсөл батлагдлаа. 66.7 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

Ингээд хоёр дахь асуудалдаа оръё.

Хоёр.Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг би Та бүхэнд танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэргэжилтэн Э.Сугарбаяр, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Жижиг,

дунд үйлдвэрийн газрын Зээл, төслийн газрын дарга Н.Энхтөр нар оролцож байна.

Ажлын хэсгийн оролцож байгаа хүмүүсийн нэрсийг танилцууллаа.

Улсын Их Хурлын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч Мягмарсүрэнгийн Бадамсүрэн ажлын хэсгийн санал, дүгнэлтээ танилцуулна.

М.Бадамсүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын аж үйлдвэрчдийн бодлогын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолоор жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилт болон жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зээл олголт, эргэн төлөлт, зээлийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн миний бие, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, П.Ганзориг, М.Ганхүлэг, Х.Жангабыл, С.Замира, Г.Лувсанжамц, Г.Очирбат, Б.Пунсалмаа, Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, Д.Энхтуяа нар.

Мөн тус ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиг үүрэгтэйгээр Байнгын хорооны ажлын алба, Улсын Их Хурлын гишүүний ажлын алба, Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, “Хөгжлийн шийдэл” төрийн бус байгууллага зэрэг дэмжих багийн бүрэлдэхүүнтэй 5 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг, хуралдаан зохион байгуулж 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 06 сарын 23-ны өдрүүдэд ажиллалаа.

Аж үйлдвэрчдийн бодлогын байнгын хороо “Хөгжлийн шийдэл” төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын өнөөгийн байдал, хууль тогтоомжийн шинэчлэх хэрэгцээ шаардлага сэдэвт судалгаа хийлгэж, судалгааны үр дүнгээс хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбоотой санал, зөвлөмжийг боловсруулсан.

Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш цуврал хэлэлцүүлгийг зүүн бүсийн Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудад, говийн бүсийн Дорноговь аймагт зохион байгуулж нийт 200 гаруй иргэд оролцож, 600 гаруй саналыг ирүүлсэн.

Монгол Улсын бүс нутаг бүрд бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй 880 жижиг, дунд бизнес эрхлэгчдээс авсан

санал асуулгын дүгнэлт, цуврал хэлэлцүүлгээс гарсан санал бичил, жижиг, дунд бизнест төрөөс үзүүлж буй дэмжлэгийн талаарх гадаад орнуудын туршлагад үндэслэн дараах санал, дүгнэлтийг боловсрууллаа.

Ажлын хэсгийн танилцуулга, санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэн танилцуулж байна.

1.Жижиг, дунд үйлдвэрийн газрын харьяалал, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт.

1.1/жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих болон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайтар хангах.

1.2/Одоогийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг бичил бизнесийг дэмжих сан болгох. Харин жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний дэмжих зорилгоор санхүүгийн корпорац байгуулж, менежментийг сайжруулах.

1.3/аймаг орон нутагт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих бүтцийг оновчтой болгон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрыг хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний газар болгон бүтцийн өөрчлөлт хийх.

Мөн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвүүдийг орон нутгийн онцлогт нийцсэн төв болгон зохион байгуулах.

2.Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зээлийн хүртээмж, эх үүсвэр, хэмжээ, эрх зүйн орчны шинэчлэл хийх.

2.1/Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан Зээлийн батлан даалтын санд улсын төсөв, Үндэсний баялгийн сангийн хөгжлийн сан, Орон нутгийн хөгжлийн сангаас хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэр хуваарилах, тогтмол нэмэгдүүлэх талаар эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх.

2.2/Гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламжийн хөрөнгийн тодорхой хувийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт санхүүжилт олгоход чиглүүлэх.

3.Бага хүүтэй, урт хугацаатай зээлийн хүртээмж олголтыг нэмэгдүүлэх.

3.1/Бүс нутгийн болон салбарын онцлогт нийцүүлсэн зээлийн хөтөлбөрүүдийг боловсруулах.

3.2/жигжиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд олгох үл хөдлөх хөрөнгө тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын зээлийг 10 жилээс доошгүй хугацаатай, эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлийг 5 жилээс доошгүй хугацаатай олгох.

3.3/лизинг, хөрөнгө оруулалт, бичил зээлийн багц зэрэг санхүүгийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, олон хувилбартай зээлийн бүтээгдэхүүн гаргах.

3.4/Жигжиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зарцуулалтын тодорхой хувийг гадаадаас эх орондоо эргэн ирж гарааны бизнес эхлүүлж байгаа бизнес эрхлэгч болон нийслэлээс орон нутагт шилжиж гарааны бизнес эхлүүлж байгаа бизнес эрхлэгчид олгох зохицуулалтыг бий болгох.

3.5/Дотоод гадаадын байгууллагуудаас зохион байгуулдаг бизнесийн сургалтад хамрагдаж, итгэмжилсэн гэрчилгээ авсан бизнес эрхлэгчийн тэргүүн ээлжид санхүүжих тогтолцоог бий болгох.

3.6/Нийт зээл олголтын 50-иас дээш хувийг газар тариалан, хөдөө аж ахуйгаас бусад боловсруулалт, үйлдвэрлэл, өндөр технологийн салбарын гарааны бизнест олгох.

3.7/Гадаад болон дотоодын аж ахуйн нэгжтэй 2-оос дээш жилээр байгуулсан бизнесийн гэрээг барьцаа олгох боломжийг бүрдүүлэх.

3.8/Жигжиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас зээл авсан, зээл авахаар хүсэлт гаргасан бизнес эрхлэгчдийн мэдээллийг боловсруулж, тогтвортой, тууштай үйл ажиллагаа явуулж байгаа жигжиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн онцлогийг тодорхойлж тухайн салбарт чиглэсэн зээлийг тэргүүн ээлжид шийдвэрлэх.

4.Зээлийн санхүүжилтийг үе шаттай зээл олголтын хугацааг тасралтгүй байлгах.

4.1/Зээлийн хөтөлбөрийг бүс нутгийн онцлог, цаг агаар, газар зүйн байршил, үйлдвэрлэлийн төрөл зэрэг дээр үндэслэн ялгавартайгаар хэрэгжүүлж, зээлийн санхүүжилтийг үе шаттай, зээл олголтын хугацааг тасралтгүй байлгах.

4.2/Ногоон санхүүжилтийн зээлийн хөтөлбөрийг санаачлан боловсруулах.

5.Зээлийн шалгуур баримт бичгийн шаардлагыг хөнгөвчлөх.

5.1/Жигжиг, дунд бизнесийн онцлогт тохирсон зээлийн шалгуур үзүүлэлт, баримт бичгийн шаардлагыг ялгаатай боловсруулах.

6.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвийн хүртээмж, менежментийг сайжруулах.

6.1/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвийг аймаг, дүүрэг бүрд байгуулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх.

6.2/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ дэмжих төвийн үйл ажиллагааг төр, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бий болгох.

6.3/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ дэмжих төвийн үйл ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгах.

6.4/Дэмжих төвийн барилгыг иргэд, аж ахуйн нэгжид нээлттэй болгож, хамтын оффис хэлбэрээр ашиглах боломжийг бүрдүүлэх.

7.Ажлын байрны түрээс худалдан авалтад чиглэсэн дэмжлэг.

7.1/Ажлын байрны түрээсийн төлбөрийн тогтвортой байдлыг хангах, гэнэтийн болон үндэслэлгүй үнийн өсөлтөөс түрээслэгчийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсруулж хэрэгжүүлэх.

7.2/Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглагдахгүй байгаа барилга, байгууламжийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд ашиглуулах, хөнгөлөлттэй нөхцөлөөр түрээслүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

7.3/Газар олголтыг хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу ил тод, нээлттэй, зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

8.Ажиллах хүчний хомсдолыг бууруулж, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх чиглэлээр.

8.1/Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, жижиг, дунд үйлдвэрлэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хоорондын хамтын хамтын хамтын ажиллагааг сайжруулах.

8.2/Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд болон жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, сургалтын хөтөлбөрийг бизнесийн хэрэгцээнд нийцүүлэх.

9.Борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх чиглэлээр.

9.1/Уул уурхай болон боловсруулах үйлдвэрлэлийн томоохон компаниуд Үйлдвэр, технологийн паркийн ханган нийлүүлэлтийн сүлжээнд түшиглэн тэдгээрийн түүхий эд, хэрэгцээт бүтээгдэхүүнийг хангах чиглэлээр

жигжиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчээс худалдан авалт хийх эрх зүйн зохицуулалтыг хийх.

9.2/Жигжиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчээс худалдан авалт хийсэн тохиолдолд худалдан авагч талд татварын хөнгөлөлт үзүүлж, зохицуулалтыг бий болгож, жигжиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарыг шууд бусаар дэмжих бодлого хэрэгжүүлэх.

9.3/Жигжиг, дунд үйлдвэр, үйлчилгээний логистикийн төв, тээвэрлэлтийн дэд бүтцийг кластер хэлбэрээр бүсчлэн хөгжүүлэх.

9.4/Сүлжээ дэлгүүр худалдан авалтын шимтгэл зэрэг дотоодын зах зээлийн дарамтыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх.

9.5/Экспортыг дэмжих хүрээнд борлуулалтын нэгдсэн суваг бий болгох, гадаад дотоодын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх.

10.Дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах импортыг зохицуулах чиглэлээр.

10.1/Их хэмжээгээр импортолж байгаа дотоодод үйлдвэрлэх боломжтой бараа, бүтээгдэхүүний нэр төрлийн жагсаалтыг гаргаж, тэдгээрт тусгайлсан бодлого хэрэгжүүлэх.

10.2/Жагсаалтад орсон бараа, бүтээгдэхүүнд импортын зохистой квот тогтоож, татварын зохицуулалтаар дамжуулан үндэсний үйлдвэрлэгчдийг хамгаалах.

11.Гарааны бизнес эрхлэгчдэд чиглэсэн оновчтой татварын дэмжлэг үзүүлэх чиглэлээр.

11.1/Гарааны бизнес эрхлэгчдийг татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх. Жишээлбэл, бизнесийн эхний 1-ээс 3 жилд ашигт ажиллагаа тогтворжоогүй үед хувь хүний орлогын албан татвар болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварт шатлалтай хөнгөлөлт үзүүлэх. Эхний жил 100 хувь, хоёр дахь жил 50 хувь гэх мэтээр.

11.2/Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болох босгыг нэмэгдүүлэх. Үүнийг хэрэгжүүлэхдээ татварын ачааллыг шударгаар хуваарилах асуудлыг анхаарах.

11.3/Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх.

12.Бие даасан дэд бүтцийн шийдэл, инновацын дэмжлэгийн чиглэлээр.

12.1/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг эрхлэгч өөрийн хэрэгцээг хангах зорилгоор дэд бүтцийн болон сэргээгдэх эрчим хүчний жижиг эх үүсвэр тоног төхөөрөмж худалдан авахад зориулсан хөнгөлөлттэй зээлийн бодлого боловсруулж, зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх.

12.2/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг нэгдсэн дэд бүтцээр хангах зорилгоор орон нутгийг хөгжүүлэх сангуудын хөрөнгөөр сум тус бүр жижиг дэд бүтцийн төвлөрөл бүхий төвийг бий болгох бодлого хэрэгжүүлэх.

12.3/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд эрчим хүчний үйлдвэрлэгч болох бололцоог нээж, ногоон санхүүжилтийн хөтөлбөрт хамруулах.

13.Нэмэлт асуудал.

13.1/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн татварын тайлан, борлуулалтын хэмжээнд үндэслэн үйл ажиллагааны доод хязгаарыг тогтоож жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн статустай холбогдох хөнгөлөлт урамшуулал, зорилтот бүлэгт чиглүүлэх боломжийг бүрдүүлэх.

13.2/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын нэг удаагийн болон цагаар ажиллагч ажилтнуудад зориулан нийгмийн даатгалын шимтгэлийн уян хатан нөхцөл, хөнгөлөлттэй шимтгэлийн зохицуулалтыг бий болгож, хөдөлмөр эрхлэлтийн боломжийг өргөжүүлэх.

Бүсчилсэн цуврал хэлэлцүүлэг бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчээс авсан санал асуулгын үр дүнгээс дүгнэхэд тус салбарын хөгжлийг дэмжих цогц бодлого, хуулийн зохицуулалт хангалтгүй, жижиг, дунд үйлдвэрийн газрын харьяалал, бүтцийн уялдаа сул, Жижиг, дунд үйлдвэрийн хөгжүүлэх сангийн санхүүжилтийн хүртээмж нэн бага, зээлийн эх үүсвэр нэн хангалтгүй, зээлийн хугацаа хэт богино, барьцаа хөрөнгийн шаардлага өндөр, татвар, нийгмийн даатгалын дарамт, бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, дэмжих төвүүдийн хүртээмж, менежмент хангалтгүй, ур чадвартай, ажиллах хүчний хомсдолтой зэрэг олон асуудлууд тулгарч байна.

Эдгээр нөхцөл байдлыг харгалзан Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд шинэчлэл, бодлогын зохицуулалт зайлшгүй шаардлагатай гэж ажлын хэсэг дүгнэж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт болон Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, ажлын хэсгийн гишүүн Д.Батбаяр, ажлын хэсгийн гишүүн П.Ганзориг, ажлын хэсгийн гишүүн М.Ганхүлэг, Х.Жангабыл, С.Замира, Г.Лувсанжамц, Г.Очирбат Б.Пунсалмаа, Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, Д.Энхтуяа. Баярлалаа.

С.Ганбаатар: М.Бадамсүрэн гишүүнд баярлалаа.

Ажлын хэсэгт орж ажилласан бүх гишүүддээ бас талархаж байна.

Монгол Улсын хамгийн чухал асуудал болох ажлын байр, орлогыг бий болгоход хамгийн чухал энэ асуудал дээр ажилласан ажлын хэсэгтээ талархаж байна.

Ингээд ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулаад, тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Д.Бум-Очир гишүүнээр, Б.Тулга гишүүнээр тасаллаа. Ингээд Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууна.

Д.Бум-Очир: Ажлын хэсгийн дарга болон ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Маш чухал асуудал. Сая бас ажлын хэсгийн дарга өөрөө хэлж байна. Ажлын байрыг нэмэгдүүлнэ, орлого нэмэгдүүлнэ гэх мэтчилэнгийн.

Миний мэдэхийн бид энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг 90-ээд оноос хойш ярьж байгаа. Улсын хөгжилд маш чухал гэдгийг бид бүгдээрээ мэдэж байгаа. Орон нутагт олон сумдад янз бүрийн түвшний жижиг, дунд үйлдвэрлэл байгуулах алхмууд олон жилийн туршид хийгдсэн. М.Бадамсүрэн дарга үүнийг өөрөө аймгийн дарга байсан хүн маш сайн мэдэж байгаа.

Тэгээд дампуурчихдаг. Нэг ноос угаая гэдэг үү, эсвэл арьс шир боловсруулъя гэх үү, эсвэл нэг талх энэ тэр хийе гэх үү. Ингээд янз бүрийн хэлбэрээр жижиг, дунд үйлдвэрлэлүүдийг байгуулж үзсэн. Бидэнд арвин их туршлага бий.

Одоо ингээд сумдаар яваад үзэж байхад тэр байгуулж байсан жижиг, дунд үйлдвэрлэлүүд маань ихэнх нь бизнес нь цаашаа явахгүй болоод, хаалгаа барьсан байдаг. Маш түгээмэл. Одоо сум болгонд очоод л өнгөрсөн 20, 30 жилийн түүхэнд ямар ямар жижиг, дунд үйлдвэрлэлүүдийг хэн хэн байгуулж байв, яагаад яагаад тэр бизнес нь зогсов гэдгийг бид шалтгаануудыг нь нарийн мэдмээр байгаа юм.

Нэг шалтгаан байдаг. Энэ орон нутгаас дэвшсэн гишүүд бүгдээрээ мэдэж байгаа даа. Нөгөө бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь зах зээл байдаггүй. Суманд нэг талхны цех байя гэж бодъё. Худалдан авагч байдаггүй. Тэгээд хаагдчихдаг. Суманд нэг арьс шир боловсруулах үйлдвэр жижиг, дунд байгууллаа гэж бодъё. Байсан. Их олон суманд байгуулсан. Нөгөөдөх нь хаагдсан байдаг. Яасан бэ гэхээр нөгөө боловсруулсан арьс, ширээ худалдаж борлуулах боломжгүй байдаг.

Тэгэхээр мэдээж хот хүрээ газар, олон хүнтэй газар нөхцөл байдал нь арай өөр байх.

Тэгэхээр сумын асуудал бол маш төвөгтэй. Суманд орлоготой байх тухай асуудал маш чухал шүү дээ. Тэгэхээр бид энэ худалдан авалтыг нь яаж дэмжиж өгөх ёстой юм бэ? Төрөөс ямар бодлого барих ёстой юм бэ гэдэг асуудлыг л нэг гаргаж ярилцмаар санагдаж байна.

Жишээ нь, тэр арьс, шир боловсруулж байгаа үйлдвэрүүд. Одоо гадагшаа гаргаж өгөх ёстой юм уу, илүү том худалдан авагчтай холбож өгөх ёстой юм уу, эсвэл холбох тэр үүд хаалгыг нь нээх ёстой юм уу? Ямар бодлого барьж яаж ажиллах ёстой юм бэ? Ажлын хэсэг энэ асуудлыг миний бодлоор бас анхаарсан болов уу гэж бодож байна. Энэ асуудал дээр бас нэг хариулт авах гэсэн юм.

С.Ганбаатар: М.Бадамсүрэн гишүүн хариулах уу?

М.Бадамсүрэн: Зөв өө. Д.Бум-Очир гишүүнтэй санал нэг байна.

Тэгэхээр нэгдүгээрт зөвхөн энэ хуулийг өөрчлөлт оруулахаас гадна бусад олон хуулиудад дагалдаж өөрчлөлт оруулахгүй бол болохгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл уялдаа холбоог нь хангах чиглэлээр. Энд Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байна л гэж үзэж байгаа.

Ер нь монопол компаниуд бүхий л салбарт орж байгаатай холбоотой нэгдүгээрт хүндрэл үүсэж байгаа асуудал байна.

Хоёрдугаарт, төрийн худалдан авалтаар дэмжих бодлого гэж байгаа боловч энэ маань хууль, эрх зүйн орчны шинэчлэл болон энэ дээр тэр үүрэг хүлээж байгаа субъектүүдийн хувьд онцгой зохицуулалт хийх шаардлага байгаа.

Гуравдугаарт нь, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн нийтийн өмч болох газрын хэвлийн баялаг буюу уул уурхайн баялгийг олборлож, үүнийг ашиглаж байгаа компаниуд орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хуулийн зохицуулалт хэрэгтэй байгаа юм. Өөрөөр хэлбэл ил тод худалдан авалтаа зарладаг. Үүний тодорхой хувь нь орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмждэг гэдэг ийм бодлогын зохицуулалт.

Мөн Аж үйлдвэрийн паркийн манай Б.Уянга гишүүний ахалсан ажлын хэсгийн зүгээс энэ зүйл дээр хэлэлцүүлэг хийхэд бас гарсан.

Тэгэхээр Аж үйлдвэрийн паркуудыг жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих томоохон бодлого болгож уялдуулах чухал шаардлага байгаа.

Дээр нь бас нэг хамгийн чухал зүйл нь Арилжааны тухай хууль гээд өргөн баригдсан байгаа.

Ер нь худалдааны чиглэлээр зохицуулалт байхгүй байгаа. Өөрөөр хэлбэл томоохон сүлжээ дэлгүүрүүдэд нийслэлд гэхэд борлуулалт хийхээр тэр борлуулсан бүтээгдэхүүний төлбөрийг 6 сарын дараа аваа ч гэдэг юм уу. Өөрөөр хэлбэл хүнсний болон бусад жижиг, дунд үйлдвэрлэлээ том зах зээлд таны хэлээд байгаа нөгөө нийслэл том зах зээлд бараа, бүтээгдэхүүнийг борлуулъя гэхээр хууль байхгүй учраас томоохон хүндрэл учраад байгаа юм.

Дээр нь бас нэг чухал зүйл нь импортоор оруулж ирж байгаа буюу дотооддоо үйлдвэрлэх боломжтой бараа, бүтээгдэхүүний бүтэн жагсаалтыг гаргаж, энэ дээр судалгаа, дүгнэлт хийгээд, яг альныг нь дотооддоо үйлдвэрлэх боломжтой байна гэдэг энэ чиг чиглэл рүү томоохон цогц судалгаа, томоохон бодлого хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгаа гэж үзэж байгаа.

Дараагийнх нь, ялангуяа ногоон санхүүжилттэй холбоотой, орчин үеийн техник, технологитой холбоотой энэ зүйлүүд дээр түлхүү зээл олгоё. Өөрөөр хэлбэл одоогоос 10, 20-оод жилийн өмнө байсан тэр зах зээл маань өнөөдөр арай өөр технологи руу шилжсэн байгаа. Үүнтэй холбоотой өөрчлөлт хийх шаардлагатай юм байна гээд.

Тэгээд дүгнэж хэлэх юм бол бүхэлд нь зээл олголтын бодлогоо нэгдүгээрт хугацааг нь урт болгож үүнийг өрсөлдөх чадвартай болгохгүй бол 3-аас 5 жилийн хугацаатай олгохоор үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулж чадахгүй, тоног төхөөрөмж авч чадахгүй учраас технологи нэвтрүүлж чадахгүй байгаа, ажиллах хүчнээ тогтвортой ажиллуулж чадахгүй байгаа ийм нөхцөл нөхцөл байдал үүсээд байгаа юм.

Тэгэхээр энэ чиглэлээр цаашид хуулийн төслийг өргөн барихдаа энэ зохицуулалтуудыг тусгахаар ингэж төлөвлөж байгаа. Баярлалаа.

С.Ганбаатар: Асуултад хариуллаа. Ингээд Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Өглөөний мэнд хүргэе.

Ажлын хэсэгт орж ажилласан. М.Бадамсүрэн дарга үнэхээр эрч хүчтэй ажилласан. Олон аймгуудаар явсан. Олон хэлэлцүүлэг хийсэн. Ялангуяа бичил

бизнес эрхэлж байгаа, өрхийн бизнес эрхэлж байгаа, худалдаа эрхлэгчид, үйлдвэрлэгч нарын төлөөлөлтэй их уулзаж ажилласан байгаа.

Тэгээд ажлын хэсэг сайн ажилласан гэдгийг нэгдүгээрт тодотгож хэлье.

Хоёрдугаарт гэх юм бол яг энэ өрхийн бичил бизнес, үйлдвэрлэлтэй холбоотой яг энэ худалдааны тухай хууль их дутагдаад байгаа юм. Өнөөдөр яг Монголын зах зээл худалдааны салбар юу болсон юм гэхээр том аж ахуйн нэгжүүд нь аль хэзээний 21 аймаг, 9 дүүрэг, том сумдаар хүртэл ийм сүлжээ дэлгүүрүүдээ хийгээд зах зээлийг нь бариад авсан байдаг.

Тэгээд бид бодлогоор зээл өгье, дэмжье, дотооддоо үйлдвэрлэе, нэмүү өртөг шингээе, тэгээд тухайн аж ахуйн нэгж нь өрхийнхөөс бичил, бичлээс жижиг, тэгээд дунд, том бизнес болго гээд төр бодлогоор дэмжээд байдаг. Монопол болсон гэдэг юм уу, зах зээл дээр олон жил үйл ажиллагаа явуулсан худалдааны байгууллагууд нь үүнийг дэмждэггүй. Яагаад гэхээр эд нар өөрсдөө өрсөлдөгч болдог. Тэр бойжигдож байгаа бараа, бүтээгдэхүүнийг гаднын зах зээлээс оруулж ирээд тэгээд тэр үйлдвэрлэлийг устгадаг угаасаа нэг ийм технологитой болоод байгаа юм.

Тэгэхээр үүний эсрэг бид бас тэр худалдааны тухай хууль дээр нэлээн сайн ажиллах ёстой гэж бодогдож байгаа юм.

Хоёрт гэх юм бол зарим нэг саналуудыг М.Бадамсүрэн дарга аа, яг үг, үсэг, өгүүлбэрээр нь санал, дүгнэлтдээ оруулаад тогтоолынхоо төсөлд оруулж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Яаж байна гэхээр дэлхий дээр яг энэ үйлдвэрлэлийн салбар бол технологийн салбар луу явсан. Ялангуяа 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 2026 оны жилийн хөтөлбөрийг батлахдаа бид 10 мянган дээвэр гээд оруулж ирсэн байгаа.

Тэр зорилго нь юу байсан юм гэхээр ер нь манай өрх өөрсдөө эрчим хүч үйлдвэрлэдэг больё л гэсэн. Өрхийн үйлдвэрлэлээ дэмжье гэсэн. Яг үүнтэй холбоотойгоор саналаа явуулсан боловч нэлээн тийм бүрхэг, ерөнхий ногоон санхүүжилт гэдгээр оруулчхаж. Би бас олон ажлын хэсэгт ажиллаж байгаа. Ялангуяа Г.Лувсанжамц гишүүний ажлын хэсэгт ороод тогтоолын төсөл дээр нь яг үг, үсэг, өгүүлбэрээр нь оруулсан.

Одоо энэ өрхийн үйлдвэрлэл, бичил бизнесийнхэн энэ ажлын хэсэг дээр яг үг, үсэг, юугаар нь оруулмаар байна. Өгүүлбэрээр нь.

Тэгээд энэ чинь яалт ч үгүй бид эрчим хүчний салбараа яг одоо өрх рүүгээ шилжүүлж өгөхгүй бол. Би бас чуулганы индэр дээрээс ч хэлж байсан. 1990 оны мэдээлэлд ойрхон байсан одоогийн олигархууд буюу уул уурхай

салбарын олон лицензтэй эзэд гарч ирсэн. Тэд нар мэдээлэлд л ойрхон байсан. Эрчим хүчний салбар одоо яг ийм болох гэж байгаа.

Тэгэхээр үүнийг иргэд рүүгээ шилжүүлээд өгмөөр байгаа юм. Иргэд маань өөрсдийнхөө эзэмшсэн газар дээр эрчим хүч үйлдвэрлээд, тэндээсээ орлого олоод өөрийнхөө хэрэглээг хангадаг энэ боломжийг бас манай энэ ажлын хэсэг хангаж өгөх ёстой.

С.Ганбаатар: М.Бадамсүрэн гишүүн хариулах уу. М.Бадамсүрэн гишүүн хариулна.

М.Бадамсүрэн: Г.Очирбат гишүүнтэй санал нэг байгаа.

Ялангуяа эрчим хүчний бие даасан эх үүсвэрийг Монгол Улсын хувьд бүрдүүлэх нь хамгийн чухал байгаа. Өөрөөр хэлбэл сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг дэмжих чиглэлээр.

Тэгээд санал, дүгнэлт дээр жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч эрчим хүчний үйлдвэрлэгч болох бололцоог ногоон санхүүжилтийн хөтөлбөрт хамруулах гэдэг утгаар санал, дүгнэлт дээр орсон.

Тогтоолын төсөл дээр гишүүний санал гаргасан буюу айл өрхүүд сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгч болж, орлого олох бололцоог нээж байгаа “10 мянган нарны дээвэр” хөтөлбөрийн хэрэгжилтийн эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд болон холбогдох журам, тогтоолуудад нэмэлт, өөрчлөлт оруулах гэдэг энэ зүйл, заалт агуулгыг Засгийн газар чиглэл өгөх тухай тогтоолын төсөлд оруулах боломжтой байна. Үүнийг хүлээж авч байна. Оруулъя.

Тэгээд манай ажлын хэсэг тогтоолын төсөл дээрээ үүнийг нэмээд шигтгээд оруулах шаардлагатай байна гэдгийг хэлье. Баярлалаа.

С.Ганбаатар: М.Бадамсүрэн гишүүн хариулт өглөө.

Л.Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Ажлын хэсгийнхэнд амжилт хүсье.

Энд нэг ийм юу байна л даа. 3.Санхүүжилтийн эх үүсвэр зээлийн бодлогын талаар гэдгийн 2-т татвар төлөгчдийн хөрөнгөөс бус уул уурхайн баялаг болох Үндэсний баялгийн сан, Хөгжлийн сангаас жижиг, дунд үйлдвэрт жил бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэр хуваарилж байх эрх зүйн орчныг бүрдүүлэх гэсэн байна.

М.Бадамсүрэн гишүүн ээ, Хөгжлийн сан хоосон. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ хамгийн сүүлд тав дахь өдөр болгон Улсын Их Хурал дээр мэдээлэл

өгөхдөө хөгжлийн сан хоосон. 2026 оноос мөнгө төвлөрүүлнэ гэсэн мэдээлэл хийсэн байгаа.

Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 сан байдаг. Ирээдүй өв санд нь 1 тэрбум 200-аад сая доллар байгаа. Тэрийг нь Англи Францын Люксембургийн Вант Улсын банканд хадгалуулчихсан. Хуримтлалын санд нь 495.6 тэрбум төгрөг байгаа. Үүнийг бас л орон сууцын хөнгөлөлттэй зээл рүү оруулсан байгаа.

Тэгэхээр та Хөгжлийн сан гэдгээ өөрчилмөөр л санагдаад байна даа. Энэ сан хоосон шүү. Гол нэрийн бараа, бүтээгдэхүүн нөгөө эрдэс баялгийн гол нэрийн бүтээгдэхүүн зарагддаг мөнгөөр санхүүждэг шүү дээ.

Үндэсний баялгийн санг яаж санхүүжүүлэх вэ гэдэг чинь хөгжлийн санг яаж санхүүжүүлэх вэ гэдэг л тойрсон хэрүүл байгаа. Тэр боломж байвал та үүнийг сольж өгөөч ээ.

Дээрээс нь Я.Эрдэнэсайхан даргаас асууя. яг энд ажлын хэсгийн чиглэл өгч байгаа дээр Та нарын зүгээс нэмэх санал оруулах юм байгаа юу? Та бол олон жил яг энэ жижиг, дунд үйлдвэрлэл дээр ажилласан. Нэлээн амжилттай ажиллаж байсан. Сүүлд бид сонсоход Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороон дээр тайланг нь сонссон шүү дээ.

Тэгэхээр энэ дээр нэмэх санал байгаа юу? Ийм хоёр асуулт.

С.Ганбаатар: Эхлээд М.Бадамсүрэн гишүүн, дараа нь Я.Эрдэнэсайхан дарга 3 номерын микрофонд хариулт өгнө.

М.Бадамсүрэн: Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя.

Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийх ажлын хэсгийг Эдийн засгийн байнгын хорооноос байгуулсан. Үүнийг би миний бие санаачилж, тэгээд ажлын хэсгийн ахлагчаар О.Батнайрамдал гишүүн ажиллаад, ингээд бид өнөөдөр удирдамжаа батлуулах гэж байгаа. Байнгын хорооны хуралдаанаар.

Тэгэхээр Үндэсний баялгийн санд байгаа 3 төрөлжсөн сантай. Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гээд.

Ирээдүй өв сангийнх нь хөрөнгө 3.9 орчим их наяд төгрөг нь гадаадын банканд доллар хэлбэрээр хадгалагдаж байгаа гэж байгаа. Тэгээд үүнийг яг ямар зарчмаар, ямар хүүтэй, яаж хадгалж байв гэдгийг бас үзэж шалгах шаардлагатай гэж үзэж байгаа.

Мөн Л.Мөнхбаясгалан гишүүнтэй бид хамтарч Хүүхдийн хөгжлийн тухай хуулийн төсөл дээр бас ажиллаж байгаа. Тэгээд энэ хүрээндээ Үндэсний

баялгийн сангийн Ирээдүйн өв сангийнх нь хуримтлагдсан мөнгөнөөс нь бус, үүний өсөж байгаа хүүгээс нь одоогийн хүүхдийн хөгжилд зарцуулъя гэдэг ийм зүйлийг бас боловсруулж байгаа. Нэг.

Хоёрт нь, хуримтлалын сан иргэдийн нэрийн дансанд болон одоогийн иргэдэд зарцуулах зохицуулалттай.

Хөгжлийн сан нь дэд бүтцийн төсөл, арга хэмжээ болон бусад томоохон төслүүдэд зарцуулна гэсэн байгаа. Тэгэхдээ таны хэлж байгаа үнэн. Одоо Үндэсний баялгийн сангийн. Энэ дээр та харвал Үндэсний баялгийн сангийн хуульд бас өөрчлөлт оруулъя. Дагалдуулж гэдэг энэ саналыг оруулж байгаа. Бид тогтоолынхоо төсөл дээр.

Яагаад ингэж байна гэхээр энэ ЖДҮ-гийн эх үүсвэрийг бүрдүүлэхийн тулд Үндэсний баялгийн сангийн хөгжлийн санд нь хөрөнгө хуримтлуулах шаардлага байгаа. Үүнийг одоо боловсруулж байгаа төсөл дээр нь ашигт малтмалын нөөц засгийн төлбөрийн 5 хувь гэдэг зүйлийг оруулж байгаа.

Тэгэхгүй бол төсөв ашигтай гарвал хуримтлагдана гэхээр энэ тийм боломж бас бүрдэх нь маруухан байгаа учраас 5 хувь гээд яг хуримтлалын сантай адилхан ашигт малтмалын нөөц засгийн төлбөрийн 5 хувь, ашигт малтмалын нөөц засгийн төлбөрийн 5 хувь нь энд оръё гээд. Тэгээд ингээд явж байгаа.

Жишээлбэл, Газрын төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бас манай зүүн бүсийн болон говийн бүсийн 13 гишүүн хамтарч өргөн барьж байгаа. Засгийн газраас санал авахаар өгсөн. D-Parliament дээр байршуулсан. Энэ дээр зохицуулалт нь юу гэж явж байна гэхээр газрын тосны роялтын төлбөрийн 5 хувь нь Хөгжлийн санд, 5 хувь нь хуримтлалын санд.

Таны саяын асуусан компаниудын ногдол ашиг. 34 хувьд ногдох. Тэр ногдол ашгийнх нь бас 50 хувь нь хөгжлийн санд, 50 хувь нь хуримтлалын санд гээд зүгээр Газрын тосны тухай хуулийн өөрчлөлтөөр бид ийм саналаа боловсруулж, иргэдээс санал ирсний дагуу бид нарын барьсан төсөл дээр жоохон ийм өөрчлөлтүүд орох, нэмэх ийм боловсруулалт хийгдэж байгаа гэдгийг танд хэлье.

Одоо яг дүгнээд хэлэх юм бол Ирээдүй өв сан бол нөгөө хүүхдүүддээ хадгалж байгаа хөрөнгө учраас энэнээс зарцуулахад учир дутагдалтай. Харин хүүхдийн хөгжилд хүүгээс нь зарцуулж бас болох юм болов уу гэж судалж байна.

Хоёр дахь нь хуримтлалын сан одоогийн иргэдэд эрүүл мэнд, боловсрол, орон сууцад зарцуулсан учраас энэ нь жоохон тохиромжгүй.

Тэгээд хөгжлийн сан нь хөгжлийн дэд бүтэц болон жижиг, дунд үйлдвэрлэл болон үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд, бизнес эрхлэлтийг хөгжүүлэхэд өөрөө зорилго нь нийцэх учраас энэ сангаа мөнгөтэй болгох зохицуулалтыг энэ хуультайгаа хамт Баялгийн сангийн хууль дээр өргөн мэдүүлье. Хэрвээ мөнгөтэй болбол эндээсээ тодорхой хувийг нь энэ рүүгээ зарцуулъя.

Яагаад гэхээр төсвөөс ингээд хараат байгаад байж жижиг, дунд үйлдвэр сан маань болохгүй байгаад байна.

Тийм учраас төсвөөс хараат бусаар тогтолцоог нь бүрдүүлж өгөөд Баялгийн санд нь мөнгө уул уурхайн баялгаас орж л байвал тэндээсээ энэ рүүгээ жил болгон мөнгө хуримтлагддаг л байхгүй бол одоогийн байгаа сан маань ингээд нэг ямар ч нэмж хөрөнгө ордоггүй. Тэгээд байгаагаараа хүү нь 5 хувийн хүүтэй өсдөг. Тэгээд энэ өсөлт үндсэндээ тийм их оновчтой байж чадахгүй байна гэж үзээд байгаа юм.

Тийм учраас бид түрүүний их олон удаа хэлэлцүүлэг хийгээд хамгийн сүүлд энэ яам жижиг, дунд үйлдвэрлэлийн агентлагийг байлгаж байгаад юу гэж санал солилцож энэ хуулийн төсөл дээрээ оруулж байгаа вэ гэхээр одоогийн байгаа хөдөлмөр... /минут дуусав/

С.Ганбаатар: Нэмж тайлбарлах уу? М.Бадамсүрэн гишүүн гүйцээж хариулъя. 1 минут өгье.

Одоогийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нэгдүгээрт. Зүйрлэж хэлэх юм бол цэцэрлэгийн хүүхдийг бойжуулж байгаа гэсэн үг. Өсгөж байгаа.

Хоёр дахь нь одоо байгаа энэ жижиг, дунд үйлдвэрлэл сан үндсэндээ 300 хүртэл сая төгрөг буюу хуульд заасан бичил ангиллын зээлд л олгох гэж байгаа юм.

Тийм учраас одоогийн байгаа жижиг, дунд үйлдвэрлэл сангийн бичил бизнесийг дэмжих сан болгоод.

Гуравт нь, бид Үндэсний баялгийн сангийн хөгжлийн сангаасаа санхүүжилт ордог жинхэнэ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санг хараат бус корпорац хэлбэрээр байгуулбал илүү оновчтой юм уу. Ингээд хүний амьдралаа зүйрлэж хэлбэл цэцэрлэг, бага анги, дунд анги гэдэг шиг ингээд ийм шаталж бизнес эрхлэгчдээ дэмжиж хөгжүүлэх бодлогыг цогцоор нь авч үзье гэдэг ийм л нэгдсэн дүгнэлтэд хүрээд хуулийн төсөл дээрээ л тусгая гэж.

С.Ганбаатар: 3 номерын микрофонд Я.Эрдэнэсайхан дарга хариулъя.

Я.Эрдэнэсайхан: Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя.

Юуны өмнө Байнгын хорооны гишүүддээ болон ажлын хэсгийн гишүүддээ маш их баярлалаа.

Үнэхээр Жижиг, дунд үйлдвэрийн асуудал чухал гэдгийг бүгд сайн ойлгож байгаа. Ажлын хэсэгт ажиллахдаа ер нь энэ жижиг, дунд үйлдвэрийн салбарт тулгамдаад байгаа нийт саналаа танилцуулж оруулсан.

Гишүүдийн хэлж байгаа маш олон саналуудыг оруулсан байгаа. Жишээ нь, Монгол Улсын хувьд онцлогтой. Хөдөө аж ахуйн орон. Ялангуяа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, нөөцөд суурилсан ийм бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байж орон нутгийн иргэдийн хөгжил, малчдын амьжиргааны асуудал яригдаж байгаа.

Орон нутаг бас хөгжил сул байгаагийн хамгийн гол үндэс бол орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл хөгжихгүй байгаа гэдэг ийм дүгнэлт гарч байгаа юм. Өөрөөр хэлбэл орон нутагт байгаа аж ахуйн нэгжүүдийн 90 гаруй хувь нь... /минут дуусва/

С.Ганбаатар: Я.Эрдэнэсайхан даргад гүйцээж хариулах боломж өгье.

Я.Эрдэнэсайхан: 90 гаруй хувь нь жижиг, дунд үйлдвэрлэл байгаа. Томоохон уул уурхай, банк гээд л бусад нь ерөөсөө бүгд жижиг, дунд үйлдвэрлэл байгаа.

Тэгэхээр үүнийгээ дэмжихгүй болохоор нөгөө орлоготой орон нутагтай амьдрах боломж нь үүсэхгүй байгаа юм.

Тэгэхээр энэ дээр борлуулалт тал дээр үнэхээр дэмжих шаардлагатай гэдэг саналыг оруулсан байгаа. Мөн агентлаг 2020 онд байгуулагдсан. Үүнээс хойш Л.Мөнхбаясгалан гишүүний хэлдгээр харьцангуй урагшаа дэвшил орсон боловч өнөөдрийн түвшинд нэгдсэн байж бас чадахгүй байгаа. Орон нутагт өөрөөр хэлбэл бүтэцгүй байгаа.

Санхүүгийн эх үүсвэр нэн тулгамдсан асуудал. Ерөөсөө улсын төсөв дээр сүүлийн 6 жил нэг ч төгрөг тавигдаагүй. Ажиллах хүчний асуудал байгаа. Жижиг, дунд үйлдвэрийн салбарт ажиллах.

Д.Бум-Очир гишүүний хэлснээр орон нутагт байгаа жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас сүүлийн жилүүдэд зээл олгохдоо скоринг систем... /минут дуусав/

С.Ганбаатар: Асуултад хариулт авлаа. Ингээд Буянгийн Тулга гишүүн асуулт асууна.

Б.Тулга: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрье.

Тэгэхээр энэ ажлын хэсэг сайн ажиллаж, ер нь манайд тулгамдаж байгаа асуудлыг шийдэхийг зорьсон ийм саналын төсөл оруулж ирж байгаа юм байна.

Тэгэхээр та бүгдийн Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын төсөл дээр дурдсан хуулийн өөрчлөлтүүд нэлээн байна. Ялангуяа танилцуулга дээр дурдагдсан тэр санхүүжилт. Татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх гэдэг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиас давсан ийм чиглэл зохицуулалтууд байна.

Тогтоол дээр чиглэл өгөх тухай санал дээр хууль эрх зүйн орчныг эхэлж оруулж ирэх гэдэг дээрээ нэлээн фокуслах нь зөв байх. Тэгэхгүй бол Засгийн газар Их Их Хурлаас баталсан хуулийг л дагаж хэрэгжүүлнэ. Тэр утгаараа тэрийг давсан юм өгвөл энэ чинь хуулиас давсан байна гээд энэ тогтоол маань хэрэгжихгүй байх ийм шалтгаан болох вий.

Тийм учраас Засгийн газраас санхүүжилттэй холбоотой энэ хуулиудыг оруулж ирэх гэдэг дээрээ төсөл оруулж ирэх. Яагаад гэвэл тэр чинь нөгөө мөнгө санхүүтэй холбоотой хуулийн төслийг Засгийн газраас оруулна шүү дээ. Түүн дээрээ илүү фокуствал зүгээр юм шиг санаа байна.

Хоёрт нь, яах вэ, тогтоолын төсөл дээр дурдсан. Танилцуулга дээр алга байна. Ер нь бүсчилсэн хөгжлийн зарчмаа нэлээн барихгүй бол Монгол Улсын 330 сум, Улаанбаатар хотын 150 гаруй хороо ингээд 600 гаруй субъект дээр бүгд дээр нь жижиг, дундыг хөгжүүлнэ гэвэл нэгдүгээрт нөгөө төсөв маань даахгүй.

Тэгэхээр хэдүүлээ жоохон деталь руу ороод бүсчлээд, бүсчилсэн дотроо тэр чинь тэртээ тэргүй эрдэмтэн судлаачдын судалгаа гараад ирсэн байгаа. Нөгөө төвлөрлийн төв цэгүүд байгаа шүү дээ. Нэг бүс дээр ойролцоогоор нэг 3-аас 4.

Тэд нар дээрээ ер нь энэ үйлдвэрлэлүүдээ аж үйлдвэрийн паркттайгаа, бусад паркттайгаа уяж кластер маягаар хөгжүүлэх ийм санааг оруулбал яасан юм бэ. Тэгэхгүй бол хэдүүлээ жижиг, дундыг дэмжиж байна гээд бүх аймагт, бүх суманд хийнэ гэвэл нэгдүгээрт энэ маань хаана ч хүртэхгүй. Хамар ч үгүй, ам ч үгүй гэдэг шиг ийм зүйл болно.

Тэгэхээр аль нэгнээс эхлэх ёстой. Эхлэхийн тулд гарааны загвар, жишиг ийм төслүүдийг тэр бүсийн яг тулгуур төвийн төвлөрлийн цэг гэж байгаа энэ хэсэг дээрээ турших маягаар ер нь загвар гаргаж хийвэл. Тэр санааг оруулбал ямар вэ гэж хэлж байна. Өөрөөр хэлбэл энэ бүсчилсэн хөгжлийн бодлогодоо маш сайн уялдуулж, бүс бүрийн онцлогт таарсан ийм загваруудыг туршиж, магадгүй бүс бүрийн онцлогт таарсан хууль эрх зүйн орчныг татварын өөр өөр ийм тогтолцоог оруулах гэсэн ийм санаа оруулбал яасан юм бэ.

Ингэвэл хэдүүлээ бас нэг ерөнхийгөөс яг деталь руугаа орж ирж хүмүүстээ хэрэгтэй ийм юм болох болов уу гэсэн ийм нэг санал байна. Тэгээд үүнийг ажлын хэсгийн гишүүд маань анхаарна биз дээ.

Мэдээж тэгээд энэ дээр Та бүхэн дурдсан байна. Зах зээлтэй хамгийн гол нь чухал байх ёстой. Яг ний нуугүй хэлэхэд манай 330 сум дээр зах зээл үүсэхэд нэлээн хүнд. Томхон сум дээр л үүсэхээс биш жижиг сум дээр хэдэн төрийн албан хаагч л байж байгаа шүү дээ.

Тэгэхээр тэд нарын хэрэгцээг хангахад жижиг дун. Минут нэмж болох уу дарга аа.

С.Ганбаатар: Б.Тулга гишүүнд нэмэлт минут өгье.

Б.Тулга: Тэд нарын хэрэгцээг хангах зах зээлийг аягүй сайн судалж хийхгүй бол нөгөө үйлдвэртээ зориулаад төрөөс баахан дэмжлэг үзүүлээд байдаг. Зах зээл нь байдаггүй. Гарсан бүтээгдэхүүнийг нь боловсруулж чаддаггүй. Нэг бол гарсан бүтээгдэхүүн нь гарч ирээд нөгөө дэд бүтэц, зам, зайнаасаа болоод ямар ч өрсөлдөх чадваргүй болдог ийм юм болох вий.

Тийм учраас зах зээлтэй нь их холбож өгч уяж, бүсчилсэн хөгжлийн тэр нягтралын төвүүдтэй уяж. Мэдээж хилийн боомт, гадаад худалдаагаа уяж, тэгээд энэ бүс болгонд тохирсон ийм онцлогтой заалтуудыг нэмж оруулж өгөх тал дээр Та бүхэн бодож үзээч ээ гэсэн ийм саналуудыг хэлэх гэсэн юм. Бусдаар энэ асуудлыг барьж авч бас ингэж ажиллаж байгаад маш их талархаж байна.

Тэгээд та бүгдийн ажилд амжилт хүсье.

С.Ганбаатар: Буяагийн Тулга гишүүн санал хэллээ.

М.Бадамсүрэн гишүүн ээ, бас л авахаар чухал чухал саналуудыг та нар маань тогтоолын төсөлдөө тусгаж ажиллаарай.

Миний хувьд нэг асуулт байна. Хоёр асуулт байна.

Ер нь товчхондоо Монголын төр, засгийн газрууд хамгийн гол юм руугаа ордоггүй. Үнэн арчаагүй. Монгол орны хамгийн гол юм юу вэ гэвэл жирийн хүмүүс ажилгүй байна, орлогогүй байна. Хамгийн гол юм руугаа ордоггүй. Нийт Монголыг жижиг, дунд үйлдвэрлэгчид ажлын байр бий болгохын чинь 90 хувийг нь бүрдүүлж байгаа юм шүү дээ. Тэр дээр анхаардаггүй. Тэд татварын олигтой хувийг бүрдүүлэхгүй байж магадгүй. Тэр бол үнэн.

Гэтэл Рио Тинто гээд л гаднын спекулятор луйварчин орж ирээд л хамаг хөрөнгө оруулалт хамаг боловсон хүчнийг нь сороод л тэгээд л том том хэдэн уул уурхайн төслүүд дээрээ тэд төсвийн 60, 70 хувийг бүрдүүлж байж болно.

Тэднийг хүндэлж байна. Гэхдээ ажлын байрны 1-ээс 2 хувийг ч бүрдүүлж чаддаггүй шүү дээ.

Монгол оронд юу хэрэгтэй юм бэ. Ажлын байр. Тэгээд энэ чухал асуудлыг хөндөж Засгийн газарт үүрэг чиглэл өгөхөөр ажилласан ажлын хэсгийн М.Бадамсүрэн гишүүн болон нийт хамт олон энэ дээр маш их чармайлттай ажилласан.

Ямар ч байсан Монгол төрд хамгийн гол юм нь юу вэ гэдгийг танилцуулж ойлгуулахыг хичээлээ. Бид ч тэгээд жоохон чармайж ажилласан энэ Аж үйлдвэрийн бодлогын байнгын хороог улс төрчид тэгээд амыг нь хумхих нь дээ.

Монгол оронд юу чухал юм бэ. Бизнес эрхлэгч, ажил үйлдвэрлэгч, ажил, бизнес, аж үйлдвэрлэгч нарт л Монголын хамгийн чухал юм шүү дээ. Одоо Аж үйлдвэрийн бодлогын байнгын хорооноо Монголын төр ад үзээд эхэлсэн. Яагаад гэвэл бид шударга ажилласан учраас харамсалтай байгаа ч гэсэндээ сайн юманд садаа мундахгүй. Энэ бол эхний л нэг жоохон садаа. Даваад л гарна.

Би асуулт байна шүү дээ. М.Бадамсүрэн гишүүн Засаг дарга байсан. Яг асуудлын гүн рүү ордог. Манай гишүүд энд байна. Би бүгдийг нь нэрийг нь дурдах ёстой шүү. Уг нь бол.

Я.Эрдэнэсайхан дарга асууя. Хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрлэлийн сан. Нэг нь Хөдөө аж ахуйн яаман дээр байгаа. Нөгөөдөх нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр байгаа.

Ингээд өөр бусад сангууд бүгдээрээ жижиг жижиг вант улсууд. Хоорондоо ямар ч уялдаа байхгүй. Энэ тэнэглэлийг зогсооход бурхан тэнгэр бидэнд туслах болов уу. Хэзээ энэ байхгүй болох вэ? ЖДҮ-гийн зээл авсан хүмүүс нь интеграцтай. Одоо Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээл авсан хүмүүс нь гадаадын хөрөнгө оруулалтын тодорхой хувиар гэж байгаа юм шүү дээ. Монгол хүмүүсийн ажлын байрыг булаасан учраас тэр гадаадын хөрөнгө оруулагчид хөдөлмөр хөлсний доод хэмжээгээрээ орж ирж байгаа гадаад ажилтан болгон дээрээ монголчуудад уучлаарай гэж мөнгө төлдөг мөнгийг энэ ажлын байртай яаж холбох вэ? Жижиг дундтай яаж холбох вэ? Миний асуулт ойлгогдсон гэж бодож байна. Энэ дээр би хариулт авмаар байна. Хэзээ энэ бие биеэ даасан мөнгө идэлтийн энэ схем зогсох вэ? Энэ бол маш олон жил үргэлжилж байгаа. Тэгэхдээ хараагүй юм шиг бүгд явдаг.

Хоёрдугаар гол асуудал. Монголын Засгийн газрын сайд нар том том их их наядуудыг зурагтаар ярих юм.

Тэгээд яг л зурагтын цаанаас чихэр долоолгоод л яриад байгаа юм. Цагаан алт, ногоон алт, ямар алт ч гэнэ вэ баахан ухаантай ухаантай юм яриад

л. Та нарт тэгж зээл өгнө, тийм гоё мөнгө байна, 5 их наяд байна, тэдэн их наяд байна. Та нарт өгөхөөр боллоо. Газар дээрээ байдаггүй. Ерөөсөө байхгүй.

Тэр аймаг, сум, аймгийн төв, сум орон нутаг, дүүрэг тэр хашаанд энэ очдоггүй. Миний асуух гэж байгаа асуулт бол зүгээр тэр Баянхошуунд, Баянхонгорын Баацагаанд, Дорнодын Халхголд ажиллаж байгаа тэр хүн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлээд хэдэн хүнийг ажилтай болгоод өөрийгөө ажилтай болгоё гэж байгаа хүн энэ төрөөс зурагтаар яриад байгаа гоё гоё бал барам шиг юмыг авахад мэдээлэл яагаад хангалтгүй байдаг юм бэ? Яагаад нуудаг юм бэ? Энэ мэдээллүүдийг ямар журмаар авдаг вэ? Ямар журмаар өгөх гэж оролдож байгаа вэ? Энэ талаар тогтоолд олигтой юм заах боломж бий юу? Миний асуулт ойлгогдсон гэж найдаж байна.

Гуравдугаарт, цахилгаан дулаан өссөн. Би ч чуулган дээр хэдүүлээ цөөхүүлээ орилсон доо орилсон. Тэгээд чарлуулж байгаад л цахилгаан дулааныг нэмээд л хаясан. Нөгөө эрчим хүчний реформ будаа. Худлаа.

Тэгээд 3 дугаар цахилгаан станцаа бүр дэлбэлж байх шиг байна. Одоо бүр сайхан дэлбэрлээ. Ямар муухай нүгэлтэй юм бэ. Цахилгаан дулааныг өсгөөд эрчим хүчний аюулгүй байдал нь тэг болсон. Нүгэл.

Тэгэхээр цахилгаан дулаан өссөнөөс болоод жижиг, дунд үйлдвэрлэл өрхийн аж ахуйтнууд бүгдээрээ ташраараа хүндэрсэн гэж би ойлгодог. Энэ талаар судалгаа тооцоо энэ эрх зүйн орчинд нь оруулах юм байгаа юу?

Би гурван асуулт асуулаа. Хариулт авъя.

М.Бадамсүрэн: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан эх үүсвэр нь бас тийм тогтмол биш гэж хэлж болно л доо.

Тэгэхээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг цэцэрлэгтэй зүйрлэвэл хүүхдээр бол бичил санг бага ангийн хүүхэдтэй, жижиг, дунд үйлдвэрлэлийн санг дунд, ахлах ангийн хүүхэдтэй гээд. Өөрөөр хэлбэл зээлийг нь шаталж олгоод явахгүй болохоор хөл дээрээ зогсож чадахгүй болоод байгаа юм. Тэгээд зээлийн хүртээмж бага учраас ямар зүйл хэлдэг вэ гэхээр үйлдвэрлэлээ өргөжүүлбэ гэхээр танайх 2 жилийн өмнө, 3 жилийн өмнө зээл авсан. Дахиад өгөхгүй гээд. Тэгэхээр чинь яаж томрох юм бэ.

Тийм учраас үүнийг шатлаад өсгөөд явъя гээд. Энэ гадаадын орнуудын Монголд хэрэгжүүлж байгаа туршлага байна шүү дээ. Олон улсын байгууллагууд зээлийг дандаа шаталж өгдөг. Тэгээд үүнийг бид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа. Энэ дээр бол таны саналтай санал нэг байгаа. Хуулийн нэмэлт, өөрчлөлтдөө үүнийг тусгаж оруулна.

Мөн Г.Очирбат, Б.Тулга гишүүн нарын саналыг тусгаад редакц хийгээд явъя.

Эрчим хүчний хувьд таны санал үнэн.

Тийм учраас Г.Очирбат гишүүний санаачилж байгаа өрх бүр эрчим хүч үйлдвэрлээд, үүнийгээ төвийн сүлжээнд нийлүүлье, үүнийгээ өөрийнхөө жижиг, дунд үйлдвэрлэлдээ хэрэглэе. Энэ рүү нь зориулсан төсвийн бодлого болон зээлийн хөнгөлөлттэй эх үүсвэрээр үүнийг дэмжье.

Ер нь яах вэ ийм л нэг дүгнэлт гарч байгаа юм. Бид дэндүү том том юм яриад байгаа нь үнэн. Яг өрх айлын амьдралд нь хэрэгтэй зүйл нь юу вэ гэхээр хүн бүр хийж чаддаг юмаа хийхэд нь зориулж л бид дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байгаа юм. Тэгэхгүй болохоор зах зээл байхгүй, эсвэл болохгүй гээд байх юм бол хэзээ ч болохгүй.

Тийм учраас үүнийг дэмжих хэрэгтэй. Тэр нь юугаар харагдаж байна гэхээр том хэмжээний судалгаа хийхэд манай Монгол Улсын нийт дотоодын нийт бүтээгдэхүүний ердөө 5.5 хувь нь жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ байгаа юм. Энэ бол маш бага тоо.

Гэтэл дэлхийн улс орнуудад 40-өөс 80 хувь хүртэл жижиг, дунд үйлдвэрлэлийнх нь бизнес эзэлж байгаа. Энэ эдийн засгийнх нь хэмжээнд, дотоодын нэвтрүүлгийн хэмжээнд.

Тэгэхээр бид дахиад жижиг, дунд үйлдвэрлэлийг хамгийн багадаа 10 дахин нэмэгдүүлэх хэрэгтэй болж байна. Нэг.

Хоёрдугаарт нь, 20 иргэн хүсэлт өгөхөд 20 иргэний нэг л зээлийн хүсэлтийг нь шийдэж чадаж байгаа юм.

Тэгэхээр зээлийн эх үүсвэрийг 20 дахин нэмэгдүүлэх шаардлага байна гэдэг нь эндээс харагдаж байгаа.

Тэгээд цаашаа тэр борлуулалтын бодлогоор дэмжих энэ зүйлүүд нь бүхэлдээ бүсчилсэн хөгжлийн хүрээнд яаж хэрэгжүүлэх вэ гэдэг нь цаашдаа хууль тогтоомжийн хүрээнд үүнийг оруулахаас гадна үүнийг хэрэгжүүлэх дээр нэлээн том ийм цогц бодлого хэрэгтэй байгаа.

Б.Тулга гишүүний хэлдгээр Эдийн засаг, хөгжлийн яаман дээр ийм өсөлтийн төвүүд гээд гарсан байгаа. Монгол Улсын хэмжээнд. Нэг аймагт 3-аас 4 сумыг өсөлтийн төв гэж нэрлэе. Энэ төв дээрээ тулгуурлаж кластер хэлбэрээр бодлогуудаа хэрэгжүүлье гэдэг. Тэгээд энэ нь цаасан дээр байгаад байгаа л даа.

Тэгэхээр үүнийг яг энэ бодлоготойгоо уялдуулахын тулд бас л бүс, орон нутгийн санхүүжилтийг нь нэмэгдүүлж өгөх хэрэгтэй байгаа юм. Өөрөөр хэлбэл, газрын тос, уул, уурхай, ашигт малтмалаас орж байгаа орлогоос нь тодорхой хувийг нь энэ орон нутгийн хөгжлийн санд нь нэмэгдүүлж хуваарилдаг. Тэндээсээ зээлээ орон нутаг нь өөрөө шийдэж явахгүй бол. Одоо манайд 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн бизнес эрхлэгч ганцхан Я.Эрдэнэсайхан даргатай Жижиг, дунд үйлдвэрлэлийн агентлаг дээр бүх зээлээ авдаг. Энэ зээл нь жилдээ ганцхан удаа конкурс зарлаж байгаа юм шиг зарлаад ганцхан удаа өгдөг.

Тэгээд үүнийгээ судлаад явсаар байтал нөгөөдөх нь намар болдог. Тэгээд зээлээ уг нь зуны цагт аваад ашигламаар байдаг. Тэгээд энэ нь намар болдог. Бусад орнуудад бид нарын томьёолж байгаагаар Хөгжлийн сангаасаа хэрвээ сан нь хөрөнгөтэй байнгын жил бүр мөнгөтэй болбол энэ нь тогтмол хэзээ ч очоод зээл авахад шалгуураа хангасан бол авч чадах хэмжээнд боломжтой болгож өгөхгүй бол үндсэндээ энэ бол ингээд одоогийн тогтолцоо нь хууль эрх зүйн орчинд бол ерөөсөө болохгүй байгаа. Хугацаа нь хэт богино байгаа.

С.Ганбаатар: 3 номерын микрофон хариулъя.

Я.Эрдэнэсайхан: С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газартай тогтмол уулзаж ажил төрлөө уялдуулж ажиллаж байгаа. Хамгийн сүүлд өчигдөр Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрийн газартай хамтраад төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллах хамтын ажиллагааны санамж бичиг зурсан.

Энэ хүрээнд яг таны хэлээд байгаа тэр иргэн буюу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авч байгааг яаж жижиг, дундаас зээл авахад нь шууд хялбараар олгох вэ гэдгийг. Үүнийг эрх зүйн хүрээнд зохицуулахгүй бол өнөөдөр эрх зүйн зохицуулалт нь байхгүй байгаа.

Тийм учраас энэ дагуу хуулийн шинэчилсэн найруулга юм уу, хуульд нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд дагалдаж гарах хуульд нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж харж байгаа.

Мөн зөвхөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих биш МСҮТ буюу ажлын байр бий болгох сургалтууд дээр хамтын ажиллагаа хийхгүй бол нөгөө ажиллах хүчний дутагдал маш их байдаг. Тэгтэл МСҮТ гээд тусдаа нэг байгууллага тэнд яаж ажиллах хүчнийг бэлдэх вэ гээд... /минут дуусав/

С.Ганбаатар: Я.Эрдэнэсайхан даргад баярлалаа.

Зүгээр би нэг минутынхаа хугацаанд тодруулах хугацаандаа зүгээр саналаа нэмж хэлэхэд Сум хөгжүүлэх сан байна. Тендерүүдийг ерөөсөө анхаарна шүү дээ.

Одоо энэ дээр та нар яах вэ ингээд санамж бичиг зурж байна л гэж байна. Улаан ноль. Аймгуудаар би явсан. Хоорондоо зүгээр л бие биеэ таньдаггүй хүн шиг байгаа. Жижиг, дундын мөнгө ямар ч төвлөрөл байхгүй. Энэ бол монгол төр эзэнгүй байна гэсэн үг шүү дээ.

Тэгээд энэ дээр та нар маань ажилдаа тусгаж ажиллаарай. Зүгээр та нар яах вэ гайгүй болох гээд байна л гэж байна. Бүгд худлаа. Зүгээр хичээгээрэй. Энэ дээр эрх зүйн орчин дээр тэр саналуудаа сайн оруулаарай. Та нараас юу шалтгаалах вэ дээ. Тэр эрх зүйн орчин дээр нь бид хичээж ажиллая.

Тэгээд ярих юм их байгаа боловч миний хэдий хурал даргалж байгаа ч гэсэндээ миний хязгаар болсон юм шиг байна.

Ингээд тодруулж асуулт асуух гишүүд маань боллоо. Ингээд үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Г.Очирбат гишүүн үг хэлнэ. Г.Очирбат гишүүнээр.

Г.Очирбат: Байнгын хорооныхоо гишүүдийг энэ саналыг дэмжиж өгөөрэй гэж уриалах гэсэн юм.

Олон хоног ажилласан. Энэ ажлын хэсгийг ахалсан М.Бадамсүрэн дарга хууль эрх зүйн талаас нь ч тэр, жижиг, дунд яг өрхийн бизнес эрхэлж байгаа иргэддээ ч тэр, тухайн сум орон нутгийн Засаг дарга нартаа ч тэр цаг хугацаагаа их зарцуулж ажилласан. Тэгээд ажлын хэсгийнхэн маань нэлээн нягт сууж ажилласан болохоор дэмжиж өгөөрэй гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

С.Ганбаатар: Баярлалаа. Би хоёрхон үг хэлье дээ.

Ер нь тендерийг хамгийн чадалтай, хамгийн сайн, хамгийн баян компани нь авдаггүй юм шүү. Тендер төсвийн мөнгөөр тендерийн 4 том зорилгын нэг нь тухайн орон нутагт ажлын байр бий болгох гэдэг зорилго байдаг юм шүү. Тэгэхгүй тэгээд л нэг хуц ухан тавьсан юм шиг нэг хэдэн баагий л бүгдийг нь хусаад л тэгээд л баяжаад байдаг. Бусад нь бүгдээрээ хараад суугаад байдаг байж болдоггүй юм шүү.

Энэ дээр жижиг дундынхан бүгдээрээ анхаараарай. Тендерийн цаад зорилго бол жижиг, дунд үйлдвэрлэгчдийг бас хөл дээр нь босгох гэдэг агуулга зорилго тэр 4 зорилгын нэг нь байдаг. Олон улсдаа ч энэ. Энэ өөрөө төсвийн мөнгө.

Тэгэхээр үүнийг та нар тэр нөгөө интеграц, тэр уялдуулахдаа оролцуулах ёстой шүү. Та нар зүгээр нэг дэндүү жоохон хараад байна даа.

Тэгээд хоёрдугаар зүйл гэвэл технологийн төвүүдийг ажиллуулмаар байгаа юм даа. Манайхан ерөөсөө энэ жижиг, дундынхан чинь энэ олон жил боллоо. Ааруул, боорцог, авдар, тэгээд л нэг эсгий эдлэл гээд зогсоод байна шүү дээ. Гадаадынхан бид нараар тооглоод байна шүү дээ.

Энэ технологи шингээж оруулах тал дээр технологийг нь шилжүүлэх төвүүдийг тэр ЖАЙКА бол энэ дээр их сайн шүү дээ. ЖАЙКА бол үнэхээр сайн. Одоо бас ололт амжилтууд байгаа. ЖАЙКА-гийн төсөл дотор технологийн төвийг дэмжлэг үзүүлэх олон олон ажлууд бүр 2012, 2013 он хүртэл би танилцаж ярьж байсан. Тэрийгээ ажиллуулаарай.

Ерөөсөө технологи ярихгүй юм. Зах зээлийн тэлэлт ерөөсөө ярихгүй юм. Хил орчмын Өвөр Монгол, Буриад, Сибирь, Хятадын зах зээл рүү, тэгээд л Япон, Солонгос цаашаа ордог юм байгаа биз. Энэ ойрхон байгаа зах зээл рүү. Хаанаасаа хаалгач нь. Хил орчмынхоо аймгуудыг хөгжүүлж байж гүнд байгаа аймгууд маань бас бараагаа зарна шүү дээ. Бүгдээрээ дроноор зүүхгүй.

Тэгээд энэ дээр М.Бадамсүрэн гишүүн санаачлаад ахлаад хил орчмын худалдаа гээд манай Б.Тулга гишүүн бас нэлээн санаачилгатай явж байгаа. Энэ болгоныгоо Я.Эрдэнэсайхан дарга аа, ажилдаа тусгаж дэмжиж, бидэнтэй хамтарч ажиллана гэж найдаж байна.

Ингээд эцэст нь ямар ч Засгийн газар, улс төрч, Улсын Их Хурлын гишүүн, сайд ямар ч ид шидтэй ухаантай байлаа гээд нэг ширхэг ч ажлын байр бий болгохгүй. Ажлын байрыг бизнес эрхлэгчид, өрхийн аж ахуйтнууд жижиг, дунд үйлдвэрлэгчид бий болгодог. Тэдэнд үйлчилдэг туслах ёстой үүргээ яам, Тамгын газар хүнд суртал авлигалын хэрэгсэл болгохгүй л дээ. Мэдээж. Зүгээр маш сайн хичээнгүйлж үйлчлэх ёстой гэдэг дээр хүн болгон анхаарч ажиллах ёстой гэдэг үг хэлье. Би ингээд үг хэллээ.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Ингээд санал хураалт бэлдье. Хуруугаа уншуулах юм байна шүү. Ингээд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

53.3 хувиар санал дэмжигдсэн байна.

Дахиад санал хураачихъя хураах ёстой байх тэгье. Саяын саналыг хүчингүй болгох саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Би санал гаргаж байсан учраас санал хураалт.

Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гээд би хонх дуугарахаас өмнө санал гаргасан.

Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Техникийн ажилтнууддаа их баярлалаа. Маш сайн байна шүү дээ. Алхаа цохисонгүй гэж. Төрийн ажил ийм л зарчимтай явж байна. Баярлалаа.

66.7 хувиар саяын санал хүчингүй боллоо.

Ингээд саналын томьёоллоо би дахиад хэлъе. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёолол дээр нэмээд Г.Очирбат гишүүн, Б.Тулга гишүүн хоёрын саналыг редакцын засвартайгаар саналын томьёололыг баталъя гэдгээр санал хураалт явуулъя. /алх цохив/

Нийт гишүүдийн 80.0 хувь нь дэмжсэн. Ингээд 80.0 хувийн дэмжлэгээр санал дэмжигдэж батлагдлаа.

Энэ тогтоолынхоо төслийн араас Я.Эрдэнэсайхан дарга аа, М.Бадамсүрэн гишүүн ээ, тогтоолын төсөл баталлаа гээд энэ чинь өөрөө хөл, гар ургаад ингээд явахгүй шүү. Араас нь Байнгын хорооны гишүүд байнга явна шүү.

Аймаг, орон нутаг сонгогдсон тойрогтоо болон бусад тойргуудад. Бид чинь Улсын Их Хурлын гишүүд шүү дээ. Тойргийн гишүүд биш. Улсын Их Хурлыг төлөөлж байгаа учраас, улсыг төлөөлж байгаа учраас тогтоолын төслийнхөө хэрэгжилт дээр онцгой анхаарч, болж өгвөл сар болгон болж өгвөл улирал болгон тогтоолынхоо төслийн хэрэгжилтийн талаар хэдүүлээ хоорондоо ярилцаад байя. М.Бадамсүрэн гишүүн ээ, энэ дээр онцгой анхаарч ажиллана шүү. Би ч гэсэн анхаарч ажиллана. Энэ маш чухал байна.

Ингээд ажлын хэсгийн нөхдөдөө баярлалаа. Та нар маань хатавчинд суухгүй болсон. Одоо энэ тогтоолын төслийг ашиглах юм бол жоохон дээшээ суух боломж байна уу, үгүй юу л гээд хамтдаа үзье дээ. Я.Эрдэнэсайхан дарга, нөгөө хоёр сайхан залуудаа баярлалаа.

Хэлэлцэх асуудлын гуравдугаарт орж ирж байна.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Нүүрсний цэвэр технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө
боловсруулах тухай/

Ингээд “Нүүрсний цэвэр технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлъе.

Тус тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал тогтоолын төслийн талаар танилцуулна.

Ингээд Ж.Золжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Золжаргал: Та бүхэндээ танилцуулга уншиж сонордуулъя.

Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төслийн талаар танилцуулга.

Даян дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн Парисын гэрээ, НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг COP-26 чуулга уулзалтаас гарсан шийдвэрүүд хүлэмжийн хийн ялгаралыг бууруулж, нүүрсний хэрэглээг багасгах шаардлагыг бий болгож байна.

Гэтэл Монгол Улсын эрчим хүч, аж үйлдвэр, эдийн засаг нь нүүрсэнд тулгуурласан байдаг.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүлэмжийн хийн ялгарал өндөртэй хүнд аж үйлдвэрийн томоохон төслүүд хэрэгжүүлэхээр, нөгөө талдаа хүлэмжийн хийн ялгаралыг бууруулна хэмээн тусгасан байна.

Эдгээр зорилтууд нь харилцан эсрэг бөгөөд аль алийг нь хэрэгжүүлэхийн тулд аж үйлдвэрлэлийн хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах, технологийн болон удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6.4-д 2021-2030 онд эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгаралыг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлнэ гэж, 2041-2050 онд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийн зөрүүг тэглэнэ гэж тусгасан.

Мөн “Алсын хараа-2050”-д 4.2.11-д зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, нефть, хими, кокс, хими, металлургийн үйлдвэр, нүүрс угаах үйлдвэр, нүүрс, хими, нүүрс, эрчим хүч, метан хийн үйлдвэрлэл, технологийн парк, ган, төмөрлөгийн үйлдвэрлэл, жонш баяжуулах үйлдвэр, алт цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулна гэж заасан.

Ингээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан 14 мега төслийн 9 дугаарт нь

►Нүүрс, хими, кокс, химийн цогцолборыг ашиглалтад оруулна гэж.

▶ Хүрэн нүүрсний ордыг түшиглэсэн цахилгаан станц барина гэж.

▶ Зүүн бүсийг говийн бүстэй интеграцалж, кокс, химийн бүтээгдэхүүн болон нүүрс, эрчим хүчний үйлдвэр, бусад дагалдах үйлдвэрлэлийг технологийн паркийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна гэж.

▶ Дорноговь аймагт дотоодын түүхий эд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулна гэж.

▶ Газрын овор элемент боловсруулах үйлдвэрийн төслүүдийг бодлогоор дэмжинэ гэж. Багануур, Налайх, Багахангай дүүрэгт хүнд үйлдвэрлэл, технологийн паркуудыг хөгжүүлнэ гэж.

▶ Нүүрс, химийн технологийг эзэмших, хүний нөөцийг бэлтгэх, ирээдүйн томоохон төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлох зорилгоор туршилт, тохиргооны бага оврын үйлдвэр байгуулан, хийн түлш, нийлэг материал, устөрөгч гарган авна гэж.

▶ Хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлж, нүүрстөрөгчийн кредит тооцох, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэн ногоон санхүүжилт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн салбар дундын зохицуулалтаар хангах эрх зүйн орчныг сайжруулна гэж тус тус заасан.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд нүүрсний цахилгаан станцуудын үр ашгийг дээшлүүлэх, хүлэмжийн хийг газрын тосны олборлолт, барилгын материал, химийн үйлдвэрлэлд ашиглах, хүнд үйлдвэрүүдийг харилцан уялдуулах зэрэг хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах технологи нэвтрүүлэх, мөн хөрөнгө оруулалтыг татах татварын болон бодлогын бусад дэмжлэгийг тодорхойлж эрх зүйн орчныг сайжруулах шаардлага тулгарч байна.

Иймд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтуудыг биелүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу нүүрсний цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгохоор Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү гэсэн байна.

С.Ганбаатар: Би микрофонгүй ярьсан юмыг нь заавал микрофон дээр бас би тайлбарлаж ярих ёстой. Монгол төрийн ажилд бас нууц юм байхгүй.

Үндсэн санаа нь Ж.Золжаргал гишүүн чухал санал гаргаж байна. Энэ тогтоолын төслийг хэрэгжүүлэх ёстой Засгийн газар, түүний харьяа Эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн яам, уул уурхайн асуудал хариуцсан энэ яам нь энд

нүүрсний асуудлаар стратеги төлөвлөгөө гаргаад өгвөл бид хэрэгжүүлэхэд их амар байна гэдэг бодлогын уялдаагаа ярьчихаад орж ирж байгаа юм байна гэж.

Ж.Золжаргал гишүүн ээ, зөв үү миний санаа. Тийм ээ.

Ингээд өөрөөр хэлбэл Улсын Их Хурал, тэр дундаа Байнгын хороо бас үүнтэй холбоотой өөрөөс шалтгаалах ажлынхаа даалгаврыг биелүүлэх утгаар ажил хэргийн байдлаар шуурхай орж ирж байгаа юм байна. Ойлголоо.

Ингээд танилцуулгатай холбоотой, Байнгын хорооны тогтоол гаргахтай холбоотой Ж.Золжаргал гишүүний танилцуулсан энэ асуудалтай холбогдуулж асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Д.Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа.

Ингээд Болдын Уянга гишүүн асуулт асууна.

Б.Уянга: Тогтоолын төслийг дэмжиж байгаа. Ж.Золжаргал гишүүн ээ.

Тэгээд одоо яах вэ, зүгээр энэ хүлэмжийн хийн бууралтай холбоотой асуудлууд энэ тогтоолын төслөөр өгөгдөөд ингээд яам руу хэрэгжилтийг нь хангуулахаар өгч байгаатай холбоотойгоор заавал нэг асуудлыг асууж таны үзэл бодлыг сонсох ёстой байх.

Тэгэхээр та бид хэд ч гэсэндээ ер нь саяхан нэг ярилцсан юм. Улаанбаатар хот, ер нь энэ орчны бохирдолтой холбоотой, агаарын бохирдолтой холбоотой асуудлуудыг яаж шийдвэрлэх вэ гээд ажлын хэсэгт хүртэл хамт орж ажилласан.

Тэгээд бид бүгдээрээ л мэддэг шүү дээ. Тийм ээ. Аливаа нэг зорилго нь агаарын бохирдолгүй байх. Тэгэхийн тулд үе шаттай ажлуудыг авч хэрэгжүүлэх ёстой байгаад байдаг.

Тэгээд сүүлийн хэвлэл мэдээллээр харж байгаа таны өгч байгаа өнцөг бол хагас кокстой холбоотой нэлээн их асуудлуудыг хөндөж ярьж байгаа. Тэгээд яах вэ, зүгээр мэргэжлийн хүрээнд санал нэг.

Гэхдээ энэ нэг авч Улаанбаатар хотыг утаагүй болгох гэж оролдож байгаа энэ үе шаттай арга хэмжээнүүдийн нэг нь биш үү? Хагас кокс гэхээр Монгол улсаас гарч явж байгаа коксждог нүүрсийг эргээгээд худалдаж авах гэж байгаа юм шиг ингээд ойлголт төрөөд байх шиг байгаа юм. Ирж байгаа хувь мессежүүд хүртэл.

Тэгэхээр уг нь энэ маань манайхаас гарч байгаа бүтээгдэхүүн хагас кокжчихдог нүүрс байлаа гэж бодоход аль нэг оронд дахин нэг тийм үйлдвэрлэлийн процесст ороод өөр хагас кокс, семикокс гэдэг нэртэй нэг тийм жигнэгдчихсэн, 500-аас 700 градуст жигнэгдчихсэн бүтээгдэхүүн Монгол Улсад

орж ирэх гээд байгаа юм. Тэгээд агаарын бохирдол хоёр дахин буурах болов уу гэсэн ийм хүлээлттэй нийслэлийнхэн ажиллаад байх шиг байгаа юм.

Тэгээд яах вэ, зүгээр гаднаас нь харахад шүүмжлэхэд амархан л байгаа юм л даа. Тэгэхдээ бүх талаас нь бодож үзвэл миний бодлоор үүнийг тийм агаарын бохирдолгүй болгох л үе шатын нэг ажил юм шиг.

Улаанбаатар төсөл гээд манай Г.Лувсанжамц гишүүний төсөл бас байгаа. Энэ орчны бохирдолтой холбоотой. Эцсийн зорилго нь яндангийн тоог бууруулах. Гол үйл ажиллагаа нь ногоон зээлийн санхүүжүүлэлтийг л дэмжих гэж байгаа.

Тэгэхээр одоо чинь бид ингээд 7 сар луу дөхлөө. Ер нь хэрэгжилт нь болохоороо айл өрх зээл авна. Ногоон санхүүжилтийн зээл авна. Тэгээд яндангийн тоогоо буулгах хүрээнд айл өөрсдийгөө дулаалах байгаа юм. Гэр орноо.

Тэгэхээр бид нарт яг энэ өвөл энэ дулаалгын асуудлуудыг бүрэн шийдэх. Тийм ээ. Одоо нэгэнт л түлш авахад асуудалтай болоод байгаа юм чинь. Ийм боломж ер нь байна гэж цаг хугацааны хувьд та бодож байна уу? Энэ дээр та саналаа хэлээд өгвөл олон хүмүүс хувь чат асуугаад байгаа учраас боломж гарсан дээр танаас асуугаадахъя. Тэгээд хариултыг бас эх үүсвэртэйгээр өгөх нь зөв байх.

С.Ганбаатар: Болдын Уянга гишүүн асуулт асуусан. Ж.Золжаргал гишүүн хариулах уу? Санал байсан уу? Асуулт байсан. Тэр дотор бас асуулт байсан шүү.

Ж.Золжаргал: Энэ нөгөө шахмал түлштэй, агаарын бохирдолтой холбоотой асуулт байна.

Улсын Их Хурал 06 дугаар сарын 05-нд тогтоол баталсан. Тогтоол нь болохоор нөгөө агаарын бохирдлын эсрэг сонсгол, нийтийн сонсголын үр дүнд ажлын хэсэг дүгнэлтээ гаргаад тэгээд Улсын Их Хурал дээр тогтоол баталсан. Тэр тогтоол дээр байгаа 11 дүгээр зүйлийнх нь агуулга нь утаа гаргадаг зуух, түлшинд төсвийн мөнгө зарцуулахгүй гээд биччихсэн байгаа юм. Тэрнээс 5 хоногийн дараа нийслэлээс тендер зарлаад Хятадаас хагас коксжсон шахмал түлш авах тендер зарласан.

Тэгэхээр тогтоол хэрэгжих ёстой учраас нэг бол тогтоолоо Улсын Их Хурлын нэгдсэн чуулган хуралдуулж өөрчлөх, эсвэл нийслэл тендерээ цуцлах ийм нөхцөл үүсэж байгаа.

Тогтоолыг олон намаас бүрдсэн ажлын хэсэг утааны сонсголыг их том ажлын хэсэг зохион байгуулсан. Ажлын хэсгийн ахлагч нь Ж.Чинбүрэн гишүүн. Одоо Ж.Чинбүрэн сайд ингээд баталсан байгаа.

Тэгэхээр энэ их олон хүний өнцөг орж байж л яригдсан зүйл л дээ. Тэгээд чуулган дээр батлагдсан. Түлшинд мөнгө зарцуулахгүй гэдэг бол их ийм ноцтой үр дагавар буюу шилжилтийн маягийн юм. Одоо түлшинд биш утаа гаргадаггүй дулаанд зарцуулъя гэсэн тиймэрхүү логик яваад байгаа юм. Тэгээд ард нь энэ дулаалгын аян гээд бас түрүүний дурддаг зүйл эхлээд яваад байна гэж би харж байгаа.

Тэгэхээр би бол их тийм экстрим дүгнэлт гэж бол үүнийг үзэж байгаа. Тэгээд ямар ч байсан гишүүд ярилцаж байгаад ийм тогтоол Улсын Их Хурал баталсан. Тэгэхээр үүнийг бол хэрэгжүүлэх хэрэгтэй, эсвэл өөрчлөх хэрэгтэй гэсэн үг.

Хувийн зүгээр техникийн хувьд хувийн бодлоо хэлэхэд Хятадаас нүүрс боловсруулсан хагас кокс түлш авна гэдгийг зарчмын хувьд дэмжихгүй. Олон жил үүнийг дандаа л эсэргүүцэж явж байгаа. Сайн чанарын чулуун нүүрсийг шигшээд жижиг биш жигд бөхлөхтэй болгоод ашиглах, нунтгийг нь шахаад ашиглах адилхан үр дүнд хүргэнэ. Үүнийг Монголын нүүрсний тэр ханган нийлүүлэгчтэй цуглуулаад уулзаад ярихад шийдлийг нь гаргаад л ирэх байх гэж би боддог.

С.Ганбаатар: Болдын Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Өнөөдрийн манай Байнгын хороог бол яг энэ асуудалтай холбоотойгоор нийслэлээс үзэж байгаа байх гэж найдъя. Тэгээд яах вэ, зүгээр яг энэ асуудлыг хагас коксыг бүтээгдэхүүн байдлаар нь оруулж ирэх дээр эрдэмтдийн дүгнэлт гарсан гэж ойлгосон.

Тэгэхээр энэ дүгнэлтийг яг энэ хэрвээ Байнгын хороог үзэж байгаа тохиолдолд энэ дүгнэлтээ яаралтай Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд ирж танилцуулаач ээ. Хэн гэдэг эрдэмтэд яг ажилласан юм, ямар баг ажилласан юм. Тэрнийх нь мэдээлэл дээр нь нэлээн нарийвчилж суух хэрэгтэй байх гэж бодож байна.

Ирэх жил бүгдээрээ ирээдүйнхээ хойч үеийн төлөө, залуучуудынхаа эрүүл мэндийн төлөө агаарын бохирдолгүй ямар нэгэн байдлаар л багасгасан байх ёстой. Хувь хэмжээг нь.

Тэгэхээр энэ дээр хамтарч ажиллахад бэлэн байгаа гэдгээ илэрхийлье.

С.Ганбаатар: Жаргалсайханы Золжаргал гишүүн хариулъя.

Ж.Золжаргал: Өнөөдөр 13 цаг 30 минутаас Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаан дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд удирдлагууд ирж

өвөлжилтийн бэлтгэл, тэр хүрээндээ шахмал түлшний асуудлаар мэдээлэл өгнө.

Тэгээд энэ дээр хэлэлцүүлэг явахаар төлөвлөгдсөн байгаа.

С.Ганбаатар: Сая Ж.Золжаргал гишүүн ээ, Б.Уянга гишүүний маш чухал санал хэлж байна шүү дээ. Юу гэвэл ер нь ингээд л Монгол даяараа ямар нэг асуудлыг л шуугидаг. Утаа ч байна уу, нүүрс ч байна уу.

Бие даасан хөндлөнгийн шинжээч, эрдэмтдийн дүгнэлт гаргаад дүгнэлтээ тойрч улс төрчид, сайд нар, их мэдэгч нар ярихгүй бол болдоггүй юм л гэдгийг хэлж байна шүү дээ.

Тэгээд нүүрсний шинжээч эрдэмтэнгүй улс гэж бол биш байх. Тэгэхээр энэ дээр тэр эрдэмтдийн дүгнэлтээ гаргаач ээ гэдгийг л яриад байна шүү. Би Оюу Толгой дээр дүгнэлт нь хаана байна. Уран дээр шинжээчдийн дүгнэлт хаана байна л гэж ганцхан асуудаг. Тэгээд дүгнэлтгүйгээр улс төрчид мэтгэлцэх бол энэ их тааруу зүйл гэдгийг л хэлж байна гэж би ойлголоо. Үүнийг ажилдаа тусгаасай гэж хүсэж байна.

Буяагийн Тулга гишүүнийг асуултын нэрсэнд оруулаарай. Ингээд Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууна.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Ерөнхий тогтоолын үзэл санаа концепц чухал байгаа юм.

Нэг талаасаа аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхийн тулд зайлшгүй бид нүүрсний хэрэглээг авч явахаас өөр аргагүй. Нөгөө талдаа хүлэмжийн хийн ялгаралыг бууруулна гээд томоохон бодлогын зорилтуудыг дэвшүүлчхээд байгаа энэ нөхцөлд зохицуулалт хийх оролдлогыг бас хийж байна гэж харж байна.

Гэхдээ үндэслэж байгаа эрх зүйн баримт бичигтэй холбоотой надад нэг хэд хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай нийцэж байгаа юу? Салбар салбарын нэлээн олон бодлогуудыг бид нэгтгээд тус тусдаа бодлого байхгүй ээ, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлоготой байна. Үүний дунд хугацааны хөгжлийн бодлого 10 хүртэл жилээр 8 хөтөлбөртэй байна. Хөтөлбөрийн хүрээнд шалгуур үзүүлэлтийг томъёолж гаргана гээд ингээд нэлээн нарийн заагаад оруулсан.

Төрийн албаны тухай хуулийн 53.1-ээр нь стратеги төлөвлөгөө батлах тухай заалт байгаа. Стратеги төлөвлөгөө батлах нь төсвийн ерөнхийлөн захирагчийн үүрэг, чиг үүрэгт байгаа. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн

хариуцсан салбар чиглэлийн хүрээнд стратеги төлөвлөгөө боловсруулан баталж хэрэгжилтийг хангуулна.

Хоёрт нь болохоор хуульд өөрөөр заагаагүй бол энэ стратеги төлөвлөгөө батлах журмыг Засгийн газар батална гэсэн байгаа. Өөрөөр хэлбэл энэ чинь Улсын Их Хурлаас тавих хяналт чиглэл. Одоо бид энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавина гэвэл Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай яаж уялдаж байгаа юм.

Хоёрдугаарт, нэгэнт хуулиар олгогдсон эрх хэмжээний асуудал. Аль ч салбарын сайд өөрийнхөө салбарын бодлогыг гаргаад стратеги төлөвлөгөөгөө дотроо батлаад сайдын эрх хэмжээний хүрээнд хийх зүйлийг заавал Байнгын хорооноос чиглэл авах хэрэгцээ шаардлага юу байгаа юм бол.

Зүгээр нүүрсний гээд одоо жишээлбэл нэг бүтээгдэхүүн дээр гаргаад ирлээ. Нүүрсний цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги. Тэгвэл зэсийн цэвэр үйлдвэрлэлийг, жоншны цэвэр үйлдвэрлэлийг гээд ингээд бүтээгдэхүүн болгон дээр ийм стратеги гаргах уу? Энэ болгоныг Байнгын хороогоор хэлэлцэх үү? Засгийн газрын үндэсний ажил юм биш үү? Чиг үүргийн хүрээнд. Энэ дээр ямар бодолтой оруулж ирсэн юм бол? Санаачлагчийн бодлыг сонсьё гэж бодож байна.

С.Ганбаатар: Д.Үүрийнтуяа гишүүн маш чухал өнцгийг хөндлөө шүү. Бас энэ Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд.

Жаргалсайханы Золжаргал гишүүн асуултад хариулъя.

Ж.Золжаргал: Хуулийн хувьд нөгөө Хууль тогтоомжийн тухай хууль Монгол Улс нэгдсэн нэг бодлоготой байна. Тэгээд 8 хөтөлбөртэй гээд. Тэгээд 8 хөтөлбөр болохоор их өргөн хүрээтэй.

Тэгэхээр хөтөлбөр дотор мэдээж энэ болбол биш.

Тийм болохоор төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл дээр тусгасан салбарын стратеги төлөвлөгөө боловсруулах хүрээнд гэсэн байдлаар бэлдсэн байгаа. Стратеги төлөвлөгөө буюу Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан зорилтуудыг биелүүлэх ийм богино хугацааны авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө байдлаар.

Нүүрс төрөгчийн ялгаралыг бууруулах гэдэг болохоор салбар дундын асуудал байгаа. Одоо манай эдийн засаг уул уурхай дээр тулгуурласан. Уул уурхайн тал нь нүүрс. Тээврийн салбар эдийн засагт том байр эзэлдэг. Тээврийн салбарын дийлэнх ачаа нь нүүрс.

Тэгэхээр тээврийн салбарын хүлэмжийн хийг бууруулах, эрчим хүчний хүлэмжийн хийг бууруулах, уул уурхайн хүлэмжийн хийг бууруулах, хүнд аж

үйлдвэр, боловсруулах үйлдвэрийн хүлэмжийн хийг бууруулах гэхээр дандаа нүүрсний үйлдвэрлэлтэй холбогдоод байгаа.

Тийм болохоор үүнийг стратеги төлөвлөгөө боловсруулснаараа нүүрсний тэр нэг манай энэ том төслүүд байгаа шүү дээ. Нүүрс, химийн үйлдвэр энэ тэр гээд. Тэгээд ялгарсан нүүрстөрөгчийн давхар ислийг газрын тос олборлолтод шахсанаараа усны хэрэглээ буурна, олборлолт нэмэгдэнэ.

Тэгэхээр ингээд өөрөө ийм салбар дундын зохицуулалтын шинжтэй, техникийн болон бодлогын шинжтэй учраас нүүрсний цэвэр хөгжлийн стратеги гэж боловсруулах нь зүйтэй юм гэж үзэж байгаа.

Эрчим хүчний шилжилт гээд ярьж байгаа. Эрчим хүчнээ шилжилт явахаар манайх чинь нүүрсэн дээр тулгуурласан эрчим хүчтэй улс. Тэгээд уурхайнуудаа хаачих юм бол нөгөө төрийн өмчийн ч бай, хувийн өмчийн ч бай, Багануур, Шивээ-Овоо гээд л олон мянган ажилтантай уурхайнууд яах билээ. Ер нь хааж чадах билүү?

Тэгэхээр эрчим хүчний үйлдвэрлэлийн үр ашгийг 30 хувийн үр ашгийг 50, 60 луу хүргэдэг ийм технологиуд байдаг. Эд нарыг нэмэгдүүлэх замаар хүлэмжийн хийгээ бууруулна гэвэл бас эрчим хүчний асуудал болно.

Тэгээд ийм салбар дундын уялдаатай учраас стратеги төлөвлөгөө боловсруулаад Засгийн газрын мөрийн хөтөлбөр “Алсын хараа-2050” дээр тусгасан зорилтууд руугаа явах юм байна гэж үзэж байгаа юм. Яамны л хийх ажлын үйл ажиллагааны хөтөлбөрт нь ч байгаа. Бий л дээ.

Тэгээд Улсын Их Хурлын байнгын хороо яах вэ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах энэ чиг үүргийнхээ хүрээнд энэ дээр анхаарал хандуулаач ээ. Тэгэхдээ энэ нь яг ийм тодорхой салбар дундын нүүрстөрөгчийг бууруулах хүнд аж үйлдвэрийн бодлогод зориулсан стратеги төлөвлөгөө хэрэгтэй байна. Нүүрсний, эрчим хүчний, газрын тосны энэ салбаруудын тээврийн хоорондын уялдаа холбоог хангах замаар гэж тодорхойлсон.

С.Ганбаатар: Д.Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн тэр 8 хөгжлийн хөтөлбөр дотор харин манай аж үйлдвэрийн салбарын хөгжлийн хөтөлбөр ерөөсөө зорилтот хөтөлбөр ерөөсөө байдаггүй байхгүй юу.

Уг нь өнөөдөр Монгол Улсын эдийн засаг, аж үйлдвэрийн салбар, тэр дотроо уул уурхайн салбар дээр оршин тогтнож байгаа бол төрөөс баримтлах энэ бодлогуудыг хүчингүй болгохдоо энд уул уурхай гэж салгадаггүй юм гэхэд ядаж аж үйлдвэрийн салбарын хөгжлийн хөтөлбөрийг Засгийн газар боловсруулахаар оруулсан бол тэр дотроо салбарлаад стратеги

төлөвлөгөөнүүд нь тус тусдаа Засгийн газар өөрөө батлаад явах боломж байсан.

Би харин үнэхээр Их Хурлын хувьд, Байнгын хорооны хувьд авч үзэх ёстой гэж байгаа бол бид энэ төрийн хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 8 хөтөлбөрт заасан энэ заалт дээр аж үйлдвэрийн салбарын хөтөлбөрийг тэр 6.5 дээр нэмж оруулах ёстой гэж боддог юм. Энэ өөрчлөлтийг хийх ёстой. Тэгж байж аж үйлдвэрийн салбар өөрөө бодлогоо тодорхойлж байж түүнд заасан стратеги төлөвлөгөөнүүд байх ёстой юм биш үү?

С.Ганбаатар: Д.Үүрийнтуяа гишүүн асуултаа асууж, энэ саналтай холбогдуулж байр сууриа илэрхийлнэ үү? Жаргалсайханы Золжаргал гишүүн хариулт өгье.

Ж.Золжаргал: Тэр бодлого төлөвлөлтийн тухай хууль дээр 8 заалт хэт ерөнхий, тэгээд салбарын бодлогууд байхгүй болсон гэж ер нь их олон салбарын хүмүүсээс сонсогдож байгаа. Тэгээд санал нэг байна.

С.Ганбаатар: Асуултад хариулт авлаа. Буяагийн Тулга гишүүн асуулт асууя.

Б.Тулга: Ж.Золжаргал гишүүнээс асуух асуулт байна.

Энэ орж ирсэн тогтоолын төсөлтэй холбоотойгоор. Тэгэхээр Монгол Улсын угаасаа одоо байгаа эдийн засаг нэгдүгээрт уур уурхай, тэр дотроо нүүрснээс 70, 80 хувийн хамааралтай байгаа. Нөгөө талд нь бас энэ эрчим хүчний үйлдвэрлэл, эрчим хүчний хэрэгцээ маань дутагдалтай байгаа. Богино хугацаанд нөхөх шаардлага бий.

Тэгэхээр энэ тогтоолын төслийг боловсруулахдаа Эрчим хүчний яам, Уул уурхайн яамнаас тодорхой санал нэгдүгээрт авч тэдэнтэй зөвлөсөн үү?

Ер нь зүгээр Монгол Улс тэртээ тэргүй байгаа баялгаа ашиглах, уур амьсгалын өөрчлөлт эрдэмтэд судлаачид ч гэсэн дэлхий дээр хоёр хуваагдсан байгаа шүү дээ. Нэг хэсэг нь энэ уур амьсгал дулаарал бол үе шатлалтайгаар тодорхой хугацаанд явагдаж байдаг. Үүнийг харин зарим технологи өндөр хөгжсөн эрдэс баялаг багатай улс орнууд өөрийнхөө технологийг нэвтрүүлж оруулах. Ингэснээрээ эрдэс баялагтай буюу уул уурхайн баялагтай улсуудыг илүү давуу талыг бий болгох гэдэг нэг ийм тал судлаачдын байр суурь байдаг.

Монгол Улсын хувьд аваад үзэхээр энэ уур амьсгалын өөрчлөлт бид нарын оруулсан хувь нэмэр гэх юм бол тийм ноцтой юм байхгүй. Харамсалтай нь хөдлөх гэхээр нөгөө том том стандартуудыг, нөгөө том том шаардлагуудыг хангах ийм үүрэгтэй болдог. Ингээд үндсэн хэрэглээгээ ч хангаж чаддаггүй. Бидний барих станц маань, бидний хэрэглэх эрчим хүч маань тэр хэмжээгээрээ

үнэтэй болоод байдаг. Германтай харьцуулахад. Тийм ээ. Австрали, Америктай харьцуулахад.

Тэгэхээр бид эхний ээлжид ямар нэг аргаар өөрийнхөө аль болох үйлдвэрлэж чадах, бий болгож чадах юмаа маш хурдтайгаар хэрэгцээгээ эхэлж хангаад дараа нь энэ стандарт руу шилжих ийм бодлого зорилт нь зөв биш үү гэдэг ийм санал байна.

Тэгэхээр энэ гарч байгаа тогтоол маань өөрөө эргээд манай эрчим хүчийг улам бүр үнэтэй болгох, манай эрчим хүчний хэрэгцээг хангахад заавал ч үгүй гарч байгаа энэ нүүрсхүчлийн хийгээ боловсруулж аваачаад дараачийн кластер болох нефтийн үйлдвэрлэлд ашигла гэдэг ийм дүрэм журам стратеги болох вий.

Би өөрөө Байгаль орчны дэд сайдаар ажиллаж байсан хүний хувьд сайн мэдэж байна. Бид өөрөө хөгжөөгүй байж ногоон хөгжлийн стандартыг авах гэж нэлээн ажилласан. Харамсалтай нь энэ маань өөрөө аж үйлдвэрийн салбараа ч тэр, бусад эдийн засгаа ч гэсэн нэлээн хойш нь татсан.

Одоо дэлхий дээр Америкаас өгсүүлээд энэ ногоон хөгжлийн COP-оос гарч байна. Ногоон хөгжлийн нэг ийм цонх үе гарч байна гэж харж байгаа. Энэ үед бид харин энэ нүүрс ихээр ашигладаг Польш, Япон, нөгөө хүлэмжийн хий бага ялгаралтай 4 дүгээр үеийн гэж ярьдаг. Тийм ээ. FOURTH-GENERATION гэж яриад байгаа 4 дүгээр үеийн эрчим хүчний станцуудыг магадгүй оруулж ирж нүүрсээрээ эрчим хүчээ үйлдвэрлэж чадах юм болбол олон жил Хятадуудтай, урд хөрштэй ярьсан. Энэ Зүүн Ази Азийн эрчим хүчний хэрэгцээг ханган нийлүүлэх тал дээр бид бас том тоглогч болох бололцоотой гэхээр энэ орон зайг хаах... /минут дуусав/

С.Ганбаатар: Буяагийн Тулга гишүүн бас чухал санал хэллээ. Та гүйцээгээд хэлсэн нь дээр байх аа. 1 минут гүйцээж хэлэх боломж өгье. Микрофон дээр дарчихлаа.

Б.Тулга: С.Ганбаатар даргадаа баярлалаа.

Тэгэхээр ер нь стратеги байх нь зөв. Тэгэхээр энэ стратегид л гол нь бид өөрийнхөө онцлогт таарсан дэлхий ертөнц дээр гарч байгаа энэ цонх үеийг бүрэн ашиглах юмыг нээж өгөөрэй. Тэгэхгүй бол үүнийг хаагаад их том том хүнд стандартууд тавьчихвал нөгөө хүүхдийг 18 хүрээгүй байхад нь их том хүнд ачаа үүрүүлээд, тэгээд давжаа болгодогтой адилхан. Одоо зүйрлэх юм бол.

Эрчим хүчний салбараа маш хурдан хугацаанд босгохгүй бол бид бас 2011, 2012 онд оруулсан Монгол Улсын эрчим хүчний хууль дээр долларын тэмдэгтээр буюу доллароор хийнэ гэдэг эрчим хүч, ногоон эрчим хүч, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих ганцхан хууль байдаг. Долларын заалт орсон. Үүнээс болоод л манай эрчим хүчний салбар үндсэндээ өнөөдрийг хүртэл. Нөгөө байгуулагдсан гэрээнүүд нь ч явдаггүй, станцууд ч баригддаггүй, ажиллаж

байсан нүүрсээр ажилладаг станцууд шинэ сэргээгдэх эрчим хүч, ирээдүй болсон энэ хоёроо хооронд нь дайсан болгосон ийм. /минут дуусав/

С.Ганбаатар: Санал байсан. Тийм ээ. Санал байсан биз. Болно болно. Жаргалсайханы Золжаргал гишүүн үг авъя.

Ж.Золжаргал: Яг саяын санал тийм хэрэгцээ шаардлага байгаа учраас ер нь бол энэ санал гарч ирж байгаа.

Өөрөөр хэлбэл бид дэлхий нийтээрээ цэвэр эрчим рүү шилжиж байна гээд моод хөөгөөд тэгээд Монголд тохирохгүй юмыг хэрээс их хэмжээгээр нь шахах боломж байхгүй. Тэгээд ингээд яаж цэвэр эрчим рүү шилжих вэ гэхээр л нэг сэргээгдэх яриад байдаг. Сэргээгдэх шиг сайхан юм байхгүй. Гэхдээ манай сүлжээний хүлээж авах хязгаар гэж юм байна.

Тэгээд дээрээс нь энэ олон улсын байгууллагуудаар төсөл, төлөвлөгөө хийлгээд яаж бид цэвэр эрчим рүү шилжих вэ гэхээр ёстой ингээд л тэр чигээрээ нар болно, устөрөгч гаргаж авна, ногоон устөрөгч гаргаж авна. Ингээд ерөөсөө нүүрс хэрэггүй болно гэдэг ийм санал, дүгнэлт гаргаад цаас үйлдвэрлээд байгаа юм. Нөгөөх нь Монголын хөрсөн дээр амьдрах боломжгүй.

Бид нэгдүгээрт хүйтэн өвөлтэй. Түлш хэрэгтэй.

Хоёрдугаарт, энэ олон мянган уурхайчдыг яах юм. Ажилгүй болгох юм уу. /минут дуусав/

С.Ганбаатар: 1 минут. Ж.Золжаргал гишүүн гүйцээж хариулъя.

Ж.Золжаргал: Тийм болохоор ногоон хөгжил гаргаад бүр тэглэнэ гээд “2050” дээр байгаа. 2050 он хүртэл. Тэрийгээ нэг талаасаа хэрэгжүүлнэ.

Нөгөө талдаа бид угаасаа нүүрсээ хэрэглэнэ. Түүнээсээ татгалзахгүйн тулд яах вэ гэдэг нэг талаасаа НҮБ, олон улсын байгууллагын хувьд нь бид бас тайлбартай байж байх хэрэгтэй.

Нөгөө талдаа бас бодитой техникийн болон эдийн засгийн хувьд боломжтой ийм шийдлүүдийг нэвтрүүлэх шат дарааллаа гаргана л гэсэн үг. Тэгэхдээ тэр нь үлгэрийн биш, амьдралд нийцсэн.

Таны ярьж байгаа нөгөө Японы жишээнүүд байна. Их нүүрс хэрэглэдэг. Үр ашиг нь маш өндөр учраас хүлэмжийн хийгээ бууруулчихдаг. Польшчууд бол жишээ нь тэр чигээрээ нүүрсний станцуудтай. Тэгэхдээ бид ингээд дэлхийн шаардлага хатуурахаар хүлэмжийнийг нь газрын гүнд булах гэж байгаа юм гээд талбайгаа бэлдчихсэн ингээд л байж л байдаг.

Тэгэхээр бид бас тэр хайгуул талбайгаа бэлдээд хадгалах гэх мэт иймэрхүү ажлуудыг л хийх шаардлагатай гэж үзэж байгаа.

С.Ганбаатар: Одоо Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууна. Яг энэ эрчим хүчний асуудал дээр асуулт асууна.

М.Энхцэцэг гишүүний микрофоныг нээж өгье.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Ж.Золжаргал гишүүний оруулж ирж байгаа Аж үйлдвэрлэлийн байнгын хорооноос “Засгийн газар чиглэл болгох” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй танилцлаа.

Тэгэхээр ямар тогтоолын төсөл вэ гэхээр нүүрсний цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруул гэж ийм даалгаврыг Засгийн газарт өгч байгаа юм байна гэж харж байна л даа.

Тэгээд яах вэ, ерөнхийдөө би юу гэж ойлгоод байгаа вэ гэхээр өчигдөр ч гэсэн чуулган дээр нэг шүүмжлэл гарч байсан л даа. Юу вэ гэхээр одоо ингээд парламентаас, дээрээс нь Байнгын хорооноос Засгийн газар луу тогтоолын төсөл өгдөг. Тийм ажил хий, ийм ажил хий гээд ингээд өгдөг. Жишээ нь, энэ бол ингээд юу гэдэг юм стратеги төлөвлөгөө боловсруул гээд.

Монгол Улсад нэг юм үнэн байгаа. Юу вэ гэхээр хангалттай хэмжээний цаас үйлдвэрлэгдэж байгаа. Одоо бүр ингээд техник, эдийн засгийн үндэслэл, төлөвлөгөө. Тэгээд түүндээ бүр маш их хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа юм. Төлөвлөгөө л гэнэ.

Тэгэхээр бас яг энэ бол ингээд л нүүрсний цэвэр үйлдвэрлэлтийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруул гээд л. Тэгээд л энэ бол ингээд л дахиад л цаанаа бас ингээд л өчнөөн хэдэн сая төгрөг зарцуулсан, дахиад л нэг цаас боловсруулагдах чиглэл рүүгээ явчих юм биш биз дээ гэж нэгдүгээрт болгоомжилж байна.

Хоёрдугаар асуудал нь болохоор бид ингээд л нэг ийм тийм төлөвлөгөөгөө боловсруул гээд ингээд нэг төлөвлөгөөний төлөө бүхэл бүтэн ийм тогтоолын төсөл гаргаад явах нь бас зөв үү? Жишээ нь, одоо юу гэдэг юм эрчим хүчний салбарыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруул гэсэн тогтоолын төслийг Засгийн газар луу өгч болох юм уу гээд. Ингээд нэг ийм жижиг жижиг ажлаар ингээд тогтоолын төсөл гаргаад байх нь бас хэр зүйтэй юм болоо гэж бодож байна.

Хоёрдугаар асуудал болохоор манайд бол бүр хар мянган цаас үйлдвэрлэгдэж байгаа.

Тэгэхээр энэ бас л дахиад нэг ийм цаас үйлдвэрлэх нэг ийм зорилттой ч гэдэг юм уу ийм тогтоолын төсөл Байнгын хорооноосоо гаргачхаж байгаа юм биш биз дээ? Тэн дээр бас жаахан нухацтай хандаасай л гэж бодож байна. Бусдаар бол нэг их асуулт бол алга байна. Тийм.

С.Ганбаатар: Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байвал микрофонд нэрсээ өгнө үү.

Үг хэлэх гишүүдийн нэрсийг авлаа. Ж.Золжаргал гишүүнээр үг хэлэх гишүүдийн нэрсийг хаалаа. Ингээд Ганбатын Очирбат гишүүн үг хэлнэ.

Г.Очирбат: Би тогтоолын төслийг дэмжиж байгаа. Яагаад гэхээр бид байгаа юмаа боловсруулах хэрэгтэй. Стратеги төлөвлөгөөтэй байх ёстой. Ялангуяа нүүрсний салбар дээр.

Ер нь яг одоогийн нөхцөл байдалд. Цаашдаа бид дэлхийн чиг хандлагын хөгжлөөрөө явна. Ж.Золжаргал гишүүн ээ. Энэ бол бодитой. Монгол Улсын нөөц өөрөө тэнд байгаа. Бид цаашдаа энэ ирээдүй. Одоо ер нь Монгол Улсын хөгжил яаж яваад байгаа юм гэхээр аж үйлдвэрийн 1, 2, 3, 4 дүгээр хувьсгал гээд бүгд мэдээд яриад байдаг. Тэгээд 1 дүгээр хувьсгалаа ч хийж чадахгүй гацчихсан байгаа шүү дээ. Бид нар. Тэгээд дандаа улс төрждөг. Тэгээд л аягүй ухаантай ухаантай юм яриад л баахан юм гаргаад л явах нь явдаг. Тэгээд зарим нь ажиллуулдаг, зарим нь зогсдог.

Гэхдээ бид аль болох тэр шат дамжлагуудыг алгасаад шинэ технологитой хөл нийлүүлж алхах нь л Монгол Улсын хувьд чухал ач холбогдолтой. Яг өнөөдрийн хувьд мэдээж нүүрс дээрээ бид гүн боловсруулалт хийгээд энэ стратеги нь гаргаад, ялангуяа засаг руу чиглэлүүдийг бол өгөөд явчих нь зүйтэй гэж харж байгаа.

Яагаад гэхээр бид Их Хурлын тогтоолоо барьж байгаад цаашаа засаг руугаа юм ярьдаг шүү дээ. Тэгэхгүй бол Засгийн газрынхан дураараа шийдвэр гаргаад явдаг. Бид бүгдээрээ л мэдэж байгаа. Төсөв дээр ч харагдаж байна, төлөвлөлт дээр нь ч харагдаж байна.

Хэн нэгэн Их Хурлын гишүүн дураараа очиж лоббидож янз бүрийн ажил тавьж л байгаа шүү дээ. Бодитой үнэн. Одоо энэ Боомтын сайд Б.Тулга сайд аа, үнэн биз дээ. Хэдэн гишүүд нийлээд лоббиддог шүү дээ. Тэгээд л өөрийнхөө бүс дээр аваачиж янз бүрийн юм тавьдаг шүү дээ.

Тэгэхээр аль болох юу гэдэг юм энэ мэргэжлийн Байнгын хорооноос энэ мэргэжлийн зааварчилгаа, чиглэлийг өгөөд, тэрийг нь Улсын Их Хурлаараа давуулж чаддаг бол бас их зөв л гэж харж байгаа юм. Тэрийгээ дараа нь бид барьж байж ажил хэрэг болгоод Засгийн газрыг шахаад явах нь зөв ёстой л гэж харж байгаа.

Эрчим хүчний салбарыг яах вэ энэ дээр бас хөндөөд байх шиг байна.

Ер нь цаашдаа эрчим хүч бол энэ ногоон руугаа явахаас өөр аргагүй. Аргагүй өөр ямар ч гарц байхгүй. Ялангуяа Монгол Улсын нөхцөл байдал дээр. Судалгаа ч тийм байгаа. Мэдээж сэргээгдэх эрчим хүчний салбар эхний хөрөнгө оруулалт өндөр байдаг ч гэсэн урт хугацаандаа өгөөж өндөртэй. Технологи ч тэрийг баталчихсан. Дэлхий ч тэр лүү явж байгаа.

Тэгэхээр энэ рүүгээ Ж.Золжаргал гишүүнээ анхаарч хэлж ярьж байгаарай. Та бас яах вэ бас нэг мэргэжлийн инженер хүн болохоор. Та бид 2 түрүүн Япончуудтай ч гэсэн уулзсан.

Сэргээгдэх эрчим хүчийг тэд нар хэзээ ч хаяхгүй л байгаад байгаа. Яах вэ мэдээж нүүрсний хэрэглээгээрээ өндөр. Хэрэглэдэг. Шинэ шийдэл санаа гарцуудыг гаргадаг. Тэгэхдээ л хаяхгүй л явж байгаа. Яагаад гэхээр яг Монголын нөхцөл байдалд энэ чинь илүү нөхцөл байдал эрчим хүч үйлдвэрлэхэд хамгийн их үр өгөөжтэй шүү гэдгийг л хэлж байгаа юм.

Миний хэлээд байгаа санаа бол өнөөдрийн хууль эрх зүйн орчиндоо багтаагаад тэр 20 киловаттыг үйлдвэрлэж байгаа иргэддээ өгөөд тэндээс орлого олъё гэж байгаа юм. Нэг.

Хоёр гэх юм бол тархмал эх үүсвэрээ дэмжээд өгөөч ээ л гэж байгаа юм. 21 аймаг бие даасан байдлаар өөрсдөдөө 5-аас 6 мегаваттын эрчим хүчний станц барих тийм боломжийг нь л олгохгүй байгаа шүү дээ. Манай засаг өнөөдөр. Яг л тийм байгаа шүү дээ. Бүгд л мэдэж байгаа шүү дээ. Б.Тулга сайд манайхан бүгд л мэдэж байгаа. Их Хурлын говийн бүсийн гишүүд хүртэл ярьж байгаа шүү дээ. Олон компаниуд, гаднын хөрөнгө оруулагч нар орж ирээд эрчим хүчний өнөөдрийн байгаа үнийг чинь нарны станцаар 198 төгрөг болгоод өгье гэж байгаа шүү дээ. Салхи бол өнөөдөр 150 төгрөгөөс 1 киловатт нь доошоо орсон шүү дээ. Дэлхий дээр. Үүнийгээ л хийе л дээ. Үүнийг л нээлттэй болгоод хийгээд өгөөч ээ гээд гуйгаад одоо хүртэл барахгүй байгаа шүү дээ.

Үндэсний хороон дээр нь хэлсэн, Эрчим хүчний яаман дээр нь хэлсэн, сайдад нь хэлсэн, мэргэжлийн хүмүүст нь бүгдэд нь хэлж байгаа юм. Тэгээд хоёр юмыг холиод байдаг. Нэг нь болохоор бид өрхийн үйлдвэрлэлээ дэмжье. Тэр өрхөд нь орлого олох боломжийг нь олгоё. Эрчим хүчээ өөрөө ханга гэж байгаа юм. Нөгөөдөх нь бие даасан тэр 50 мегаватт, 100 мегаваттын, аймгууд дээр 5-аас 10 мегаваттын тэр дэд бүтэц, станц барих боломжийг нь олгоод өгөөч ээ гээд. Тэрийг л хаачхаад байгаа байхгүй юу.

С.Ганбаатар: Ганбатын Очирбат гишүүн үг хэллээ. Одоо Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн үг хэлнэ.

Д.Үүрийнтуяа: Тогтоолын агуулгыг бол чухлын ойлгож байна. Гэхдээ миний хувьд Байнгын хорооны тогтоолын төсөл гэдгийг дэмжихгүй байна. Хоёр шалтгаан байна.

Нэгдүгээрт, зарчмын асуудал байна. Институт хоорондын чиг үүргийн ялгаа зааг гэдэг юм байх ёстой. Засгийн газрын хийх ёстой, гүйцэтгэх ёстой өөрийнх нь хуулиар хүлээсэн эрх, үүргийг дахиад бид Байнгын хороогоор ч үүнийг хий гэж ингэж зааж өгөөд байгаа нь. Тэгээд үндэслэж байгаа хууль нь төрийн албаны хууль буюу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх, үүрэгтэй холбоотой заалтыг барьж байгаа нь өөрөө яг Байнгын хорооны үйл ажиллагаанд хамаарахгүй байна. Энэ оновчгүй байна. Нэг.

Хоёрдугаарт, тогтоолын төслийн дотор нь агуулгаар нь аваад үзэхээр бас хэд хэдэн асуудалтай зүйлүүд байгаад байна. Тухайлах юм бол 2 дугаар заалт дээр нүүрсний цахилгаан станцуудын үр ашгийг дээшлүүлэе, хүлэмжийн хийг газрын тосны олборлолт, барилгын материал, химийн үйлдвэрлэлд ашиглах, хүнд үйлдвэрүүдийг харилцан уялдуулах зэрэг хүлэмжийн хийн ялгарлын бууруулах технологи нэвтрүүлэх гэж байгаа.

Тэгээд манай Ж.Золжаргал гишүүн бас өөрөө энэ чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн хүн технологи нэвтрүүлэх бол нэг Байнгын хорооны тогтоолоор юу гэдэг юм үүрэг өгөөд технологи орж ирж нэвтрээд суурьшдаг юм шиг тэгээд яваад байгаа. Хамгийн сайн л мэдэж байх ёстой гэж бодож байгаа.

Яг энэ хоорондоо уялдах тийм технологи юу байх юм. Технологийн сонголтоос авхуулаад судалгаа шинжилгээ гээд энэ чинь бас технологи нэвтрүүлнэ гэдэг агуулгаараа бол амаргүй л ажил л даа.

Боломжтой ч юм уу, боломжгүй ч юм уу. Үнэхээр хэрэгжих боломжгүй юмыг бид үүрэг болгож өгөх гээд байгаа юм биш биз дээ.

Гуравдугаарт, хөрөнгө оруулалтыг татах татварын орчин, эрх зүйн орчин болон бодлогын бусад дэмжлэгийг тодорхойлж эрх зүйн орчныг сайжруулах гээд байгаа. Бид нарт нэг ийм жижүүрийн хэдэн үгтэй болоод байна. Аль ч тогтоол дээр ордог.

Тэгээд үүнийг харин тодорхой агуулгаар нь зааж орсон бол ямар байх байсан юм.

Тэгээд 4 дэх заалт нь Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу дээрх хуулийн биелэлтийг зохион байгуулж гээд байгаа юм. Тэгээд дээрх хуулийн биелэлт гэдэг нь Төрийн албаны хуулиа хэлээд байгаа юм уу, юу хэлээд байгаа юм. Ер нь бол яг тогтоолын төслийн зүйл, заалтууд хоорондоо агуулгын хувьд маш их тийм уялдахгүй зөрчилтэй зүйлүүд байгаад байна.

Тийм учраас уучлаарай, би Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжих боломжгүй байна гэдэг байр сууриа илэрхийлж байна.

С.Ганбаатар: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн үг хэллээ. Буянаагийн Тулга гишүүн үг хэлнэ.

Б.Тулга: Ерөнхийдөө агуулга санааг би сая түрүүн асуултаар ойлголоо. Дэмжиж байна. Ялангуяа гадна, дотноос зээл авахад, ялангуяа барууны нөхдүүдээс юу яахад болбол танай нүүрсний юмыг бол дэмжихгүй гэдэг. Бүх бизнесийг.

Тэгэхээр бид өөрсдөө л шаварт унасан шарын эзэн. Гэхдээ энэ бол баялаг байгаа юм.

Тийм учраас хууль эрх зүйн орчин, зүйл, заалтуудаа засаад ерөнхийдөө энэ нүүрсийг манай баялаг учраас, тэгээд энэ чинь дэлхий нийтээр дутагдаж байгаа энергийн эх үүсвэр л байгаа шүү дээ. Цахилгаан машин гарч байна гээд жишээлбэл нефтийг бид бүгдээрээ хорио оо, байхгүй болго оо, ашиглахаа боль оо гэж ярихгүй л байгаа шүү дээ.

Тийм учраас нүүрсийг сайн ашиглаж чадаж байгаа, боловсруулж чадаж байгаа энэ технологиудыг Монголд оруулж ирэх. Зөвхөн ногоон болгохын болгохын тулд юу гэдэг юм нарны, салхины, усан сан үүсэх гэдгээс гадна технологиороо дамжуулж бусад таны хэлж байгаа тэр үйлдвэрүүдийн юунуудтай кластер болгож тийм ээ, харилцан бүтээгдэхүүнийг нь өгдөг барьдаг ийм болгож чиглүүлэе гэдэг зөв санаа гэж бодож байна. 100 хувь дэмжиж байна.

Хоёрдугаарт, тогтоолын юун дээр тэр төлөвлөгөө, стратеги гаргана гэсэн санаа байгаад байгаа юм. Тэгээд энэ стратеги дотор яах вэ гэхээр боловсролын салбарт мэргэжил эзэмшиж байгаа, тэтгэлэг олгож байгаа энэ зүйлийг ч гэсэн эцсийн дүндээ бид нүүрс рүү чиглүүлэх ёстой. Нүүрсийг шатаах чинь тэртээ тэргүй л энергийн эх үүсвэр байж байгаа. Нүүрсийг шатаахаас гадна шингэрүүлэх, хий болгох, тэгээд тэр хортой хийг нь ялгаж авах гээд маш олон технологиуд өнөөдөр байгаа.

Тэгэхээр энэ дээр хамгийн сайн шинжлэх ухаан технологийн парк гэдэг юм уу, хамгийн сайн эрдэмтэн судлаачид дэлхийн бүх хүмүүсийг авчирч Монгол залуучуудыг бэлдэх гэдэг нь их чухал заалт байх ёстой байх гэж бодож байна.

Тэгэхээр боловсон хүчин бэлдэх тал дээр бид онцгой анхаарал хандуулж ажиллах ёстой энэ заалт, энэ зүйлийг энэ стратеги дээр бас тусах байх гэсэн бодолтой байна. Тэгээд тэр утгаараа нүүрсээ боловсруулж өөр ямар шинэ технологиор нүүрсийг боловсруулж энергийг нь ялгаж авах ёстой байдаг юм. Энэ дээр Монгол Улс манлайлах ёстой.

Тийм учраас энэ чиглэлээр тодорхой шийдвэрийг бусад уул уурхайн бүтээгдэхүүнээс салгаж гаргаж байгаа энэ тогтоолыг дэмжиж байна гэдгийг хэлэх гэсэн юм.

С.Ганбаатар: Жаргалсайханы Золжаргал гишүүн үг хэлье.

Ж.Золжаргал: Монгол Улс цаашдаа урт хугацаанд хөгжихөд сэргээгдэх эрчим хүч чухал.

Ер нь боломжоороо тултал нь дэмжинэ. Цаашдаа ч нэмэгдээд явах нь гарцаагүй. Тэгээд сэргээгдэх эрчим хүч, эсвэл нүүрсний эрчим хүч, эсвэл шатахуун, газрын тос боловсруулах үйлдвэр. Эд нар бол эсрэг тэсрэг зүйл биш. Ингээд л холимог микс болоод л явж таарна.

Тэгэхээр яах вэ, өөрийнхөө нөхцөлд тулгуурласан бодит амьдралтай нийцсэн ийм зүйлийг бид төлөвлөх хэрэгтэй байгаа. Нүүрсний үйлдвэрлэл байхгүй бол гангийн үйлдвэр байхгүй. Гангийн үйлдвэр барина гээд төлөвлөсөн байгаа. Гангийн үйлдвэр барихаар битүү хүлэмжийн хий гарна. CO₂. Цементийн үйлдвэрүүд, барилгын материал тэр чигээрээ CO₂. Дулаалгын материал Монгол базальт, базальт үйлдвэрлэнэ тэр чигээрээ CO₂. Эрчим хүчний салбарт тэр чигээрээ хүлэмжийн хий. Тээвэр, төмөр зам бүгдээрээ нүүрс тээвэрлэж байгаа. Шатахууны шаталтаас тэр чигээрээ хүлэмжийн хий. Ус. Говийн хамгийн их усны эх үүсвэр бол нүүрсний ил уурхайнууд байдаг. Манай нүүрсний ил уурхайнууд ихэвчлэн говьд байгаа.

Тэгэхээр нөгөө говийг усжуулах эх үүсвэр чинь нүүрсний уурхайнууд юм. Тэрбум мод говьд тарих хамгийн боломжтой юм чинь нүүрсний уурхайнууд юм.

Тэгэхээр нүүрсний энэ төлөвлөлт чинь бүх салбарыг дамжиж хэрэгжинэ. Стратеги төлөвлөгөөн дээр болохоор Засгийн газрын үйл ажиллагаа хөтөлбөрт тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд хооронд нь уяж, тэрбум модтойгоо ч уях ийм шаардлага гараад байгаа юм.

Тэгээд одоо эд нарыг ингэж холбосон тийм төлөвлөгөө байхгүй байна. Эрчим хүчний шилжилт, цэвэр эрчим гэхээр хэтэрхий нэг тал руугаа яваад байна. Хэрэгжүүлэх гол газар нь Ашигт малтмал 8 эрдэс баялгийн яам. Тэгээд Эрчим хүчний яам. Дараа нь тээвэр орно.

Тийм болохоор бид угаасаа төлөвлөсөн байгаа юмыг хооронд нь уяж их цэгцтэй байдлаараа Засгийн газар төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэхийн тулд тэр төрийн албаны хуулийн стратеги төлөвлөгөө гэдэг юмыг л ашигладаг шүү дээ.

Тэгэхээр тийм их тодорхой даалгавартай стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлснээрээ хууль хэрэгжих буюу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих, тэгээд “Алсын хараа-2050” хэрэгжих суурь болно гэж үзэж байгаа юм.

Тэгээд энэ бол мэдээж яах вэ тэр үг үсгийн хувьд жишээ нь технологи нэвтрүүлэх нь тогтоолын зорилт бол биш шүү дээ. Стратеги төлөвлөгөө нь дотроо технологи нэвтрүүлэхийн тулд яах юм, хөрөнгө оруулалт татахын тулд яах юм, татвараа яаж зохицуулбал сайн байх юм, боловсон хүчнээ бэлдэхийн тулд яах юм гээд. Энэ асуудлуудыг уяж боловсруулах ёстой. Тийм утгаар л бичсэн байгаа. Тэгээд саяын ярьдаг тэр хөрөнгө оруулалт татах гээд их чухал зүйл байгаад байгаа. Одоо нүүрс дээр ингээд хөрөнгө оруулалт нь татагдсан. Олон улсууд өгдөггүй гээд. Цаана нь CO2 байдаг.

Тэгэхээр бид тэрний өөдөөс юу тавих вэ гэхээр бид CO2 дээр ийм төлөвлөгөө байна. Энэ хоёр салбарын хооронд уялдааг холбосноор тэгж буурна. Тэр нь Монголын НҮБ-д өгдөг үндэсний тодорхойлсон хувь нэмэр дээр бичигдсэн байгаа. Үндэсний тодорхойлсон хувь нэмэр бол Парисын хэлэлцээрийн үр дүнд Монгол Улсын дэлхий нийтийн хүлээж байгаа үүрэг.

Тэгээд тэр баримт бичгийг хэрэгжүүлэхийн тулд бас ялгаагүй энэ ажлууд хэрэгтэй. Тэрийг ингэж уясан төлөвлөлт цаас бол ерөөсөө байхгүй байгаа. Байхгүй байгаа учраас бичсэн хууль тогтоомж, олон улсын амлалтаа хэрэгжүүлэх алхмаа тодорхойлоод, стратеги төлөвлөгөө боловсруулаач ээ гэж хүсэж байгаа юм.

С.Ганбаатар: Асуулт асууж, гишүүд үг хэллээ.

Одоо ингээд санал хураалтдаа бэлдье. Хурууныхаа уншуулах юм байна шүү. Ингээд Нүүрсний цэвэр технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

46.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Ингээд дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Дөрөв.Үйлдвэрлэл технологийн паркийн хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмж

Хэлэлцэх асуудлын дөрөв. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санаачилгаар тус Байнгын хорооноос байгуулагдсан Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаатай танилцах, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгээс холбогдох байгууллагуудтай хамтран 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан Үйлдвэр, технологийн паркийн хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Н.Мөнх-Идэр “Эрдэнэс үйлдвэр, технологийн парк” ХХК-ийн гүйцэтгэх захирал орж ирсэн байна. Н.Баяраа “Эрдэнэс үйлдвэр, технологийн парк” ХХК-ийн хуульч. Б.Мягмаржаргал “Эрдэнэс үйлдвэр, технологийн парк” ХХК-ийн төслийн менежер. Б.Гэрлээ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль эрх зүйн зөвлөлийн зохицуулагч байна. Р.Батгэрэл Монголын Үйлдвэр, технологийн паркуудын нэгдсэн холбооны Ерөнхийлөгч ороод ирж байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд байгаа гишүүдийг танилцууллаа.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Болдын Уянга тус хэлэлцүүлгээс гаргасан санал, зөвлөмж, ажлын хэсгээс боловсруулсан Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулна.

Б.Уянга: Гишүүддээ дахин энэ өдрийн мэндийг хүргэе.

Үйлдвэр, технологийн паркийн эрх зүйн орчныг судалж, санал, зөвлөмж, дүгнэлтийг гаргах ажлын хэсэг 2024 оны 12 сарын 24-нд Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороон дээр байгуулагдсан байгаа юм.

Энэ хүрээнд ажлын хэсгийн гишүүд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Гэхдээ 2025 оны 06 сарын 10-ны өдөр Үйлдвэр, технологийн паркийн хоёр дахь удаагаа зохион байгуулагдаж байгаа форум болоод өндөрлөсөн.

Энэ хүрээнд “Эрдэнэс Монгол” нэгдэл, “Эрдэнэс УТП” ХХК, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим, Монголын үйлдвэрлэл, технологийн паркуудын нэгдсэн холбоо, форумд оролцогч үйлдвэрлэл технологийн паркийн удирдлагын компаниуд, эрдэмтэн судлаачид энэ форумыг амжилттай зохион байгуулсан.

Мөн мэргэжил, арга зүйн зөвлөгөөг Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны хамт олон үзүүлж, ийм нэг форумыг хоёр дахь удаагаа амжилттай зохион байгуулсан байгаа.

Тэгэхээр ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлт хэдий гарах арай болоогүй байгаа боловч яг энэ форумтай холбоотойгоор гарсан санал, зөвлөмжийг шинээр эмхлэгдэн байгуулагдсан Засгийн газар луу өгч байх нь зөв юм гэдэг хүрээнд энэ форумгаас гарсан нэгдсэн дүгнэлт, санал, зөвлөмж өнөөдөр танилцуулах тогтоолын хүрээнд бүх санал, зөвлөмжийг хавсаргаад Засгийн газарт хүргүүлэх тогтоолын төслийг бэлдсэн байгаа.

Тэгэхээр өнөөдөр Байнгын хорооны гишүүддээ “Засгийн газарт чиглэл өгөх” энэ тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Тэгээд тогтоолын төсөлтэй холбоотой саналуудаа асуугаарай. Ажлын хэсэгт бүх талаар дэмжиж оролцож байгаа үйлдвэр, технологийн парктай холбоотой идэвхтэй ажилладаг байгууллагын төлөөлөл өнөөдөр ирсэн байна.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 08 дугаар тогтоолоор байгуулагдсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаатай танилцах, санал, дүгнэлт гарах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн явц, түүнчлэн “Үйлдвэрлэл, технологийн паркийн хэлэлцүүлэг”-ээс гарсан санал, зөвлөмжид үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т чиглэл болгосугай.

1/Үйлдвэрлэл, технологийн паркт бодлогын дэмжлэг үзүүлэх чиглэлээр:

1/Монгол Улсад үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх стратеги, төлөвлөлт, нэгдсэн бодлогын баримт бичиг боловсруулах;

2/Ашигт малтмалыг дотооддоо боловсруулахыг түлхүү дэмжих зорилгоор үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид түүхий эдийг тогтвортой хангах боломжийг бүрдүүлж, төрийн өмчийн ордоос ашигт малтмал худалдан авах, боловсруулахад эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэх;

3/Үйлдвэрлэл, технологийн паркт ашигт малтмал гүн боловсруулах технологийн болон санхүүгийн өндөр чадавх бүхий этгээдэд шаардлагатай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг тусгай нөхцөлтэйгөөр олгох механизмыг бүрдүүлэх;

4/Үйлдвэрлэл, технологийн паркуудын хүний нөөцийг бэлтгэх, сургах чиглэлээр дэмжих хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх;

5/Үйлдвэрлэл, технологийн паркийн эрчим хүчний эх үүсвэр шинээр байгуулахыг бодлогоор дэмжих, паркийн нэгжүүдэд нийлүүлэх эрчим хүчний тарифыг чөлөөлөх талаар судалж, боломжит хувилбарыг танилцуулах.

2.Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

1/Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийг холбогдох санал, дүгнэлтэд тулгуурлан сайжруулж шинэчлэх;

2/Ашигт малтмалын нөөц ашигласан төлбөрийг зөвхөн олборлосон хүдэрт ногдуулж баяжуулах, боловсруулах үйлдвэрээс авахгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх боломжийг судлах;

3/Үйлдвэрлэл, технологийн паркийн нэгжид төрөөс үзүүлэх татварын дэмжлэгүүдийг холбогдох санал, дүгнэлт тулгуурлан илүү сайжруулж боловсронгуй болгох;

4/Үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах нэгжүүдээс төрөөс тавигдах шаардлага нь бусад аж ахуйн нэгжүүдэд тавигдах нийтлэг шаардлагаас өндөргүй байх, эсхүл илүү таатай нөхцөлийг бүрдүүлэх.

Хоёр.Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т үүрэг болгосугай

Гурав.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /С.Ганбаатар/-т даалгасугай.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар гэсэн ийм тогтоолын төслийг боловсруулаад танилцуулж байна.

Үйлдвэр, технологийн паркийн форумд Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын алба болон С.Ганбаатар дарга бүтэн хагас өдөр бүтэн байж холбогдох санал, дүгнэлтийг сонсож оролцсонд ажлын хэсгийн гишүүдийн өмнөөс талархал илэрхийлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн холбогдох хэлэлцүүлгүүдийг ахалж ажилласан Г.Лувсанжамц гишүүн, Д.Үүрийнтуяа гишүүн, Г.Очирбат гишүүн, М.Бадамсүрэн гишүүн, Ж.Золжаргал гишүүн, мөн С.Цэнгүүн гишүүн нар бас энэ хэлэлцүүлэгт оролцсон байгаа.

Тэгээд Та бүхэндээ талархал илэрхийлье.

С.Ганбаатар: Болдын Уянга гишүүндээ баярлалаа.

Манай байнгын хорооны бас л урдаа барьдаг ажлын нэг нь энэ паркуудыг дэмжье гэдэг дээр ерөөсөө л нэг гацаанд орчхоод байгаа дээр хөдөлгөөнд оруулъя гэдэг дээр манайх бас анхаарлаа хандуулсан.

Ингээд Б.Уянга гишүүнээр ахлуулж ажилласан.

Саяын танилцуулсан мэдээлэл болон холбогдох зүйлүүдтэй холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Буяагийн Тулга гишүүнээр тасалж нэрсийг авлаа. Ингээд Буяагийн Тулга гишүүн асуулт асууна. Дараа нь Ж.Золжаргал гишүүн.

Б.Тулга: Юуны өмнө сая болсон хурал дээр оролцох санаатай байсан боловч бусад хурлууд давхцаад оролцож чадаагүй.

Тэгэхээр үйлдвэр, технологийн паркууд Монгол Улсын цаашдын үйлдвэрлэлийн үндсэн бүтэц чиглэл байх ёстой гэдэг дээр миний итгэл үнэмшил бол 100 хувь байдаг. Энэ Үйлдвэр, технологийн паркуудыг дагасан түрүүний бид нарын яриад байгаа жижиг, дунд үйлдвэрлэл, зах зээл, олон улсад өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн гарах энэ бүх зүйл явах ёстой.

Тийм учраас энэ чиглэлээр Та бүхэн хоорондоо яриад, хуралдаад, форум зохион байгуулаад, асуудлуудаа яриад, нэгтгээд Байнгын хороон дээр оруулж ирж байгаад талархалтай байна. Дэмжиж байна.

Дэмжиж байгаа учраас энэ гарсан санал, зөвлөмж л юм даа. Тийм ээ. Санал, зөвлөмжийг Та бүхэн дахиад нэг юу яахыг бодоорой. Би сая гүйлгээд уншаад үзлээ. Одоо нөгөө ипотекийн зээлд хамрагдах гээд бусад юмнуудыг чирчхээр фокус алдагддаг шүү.

Тэгэхээр яг паркийнхаа үндсэн технологи, зах зээл, татвар юу гэдэг юм, эрх зүйн орчин энэ юман дээрээ фокуслахгүй бол тэндээсээ халиад нэг орон сууц гээд яриад явбал юм унах гээд байдаг юм шүү.

Тэгэхээр энэ фокусаа инженерүүд маань маш сайн тодорхой гаргаж тавьж яваарай гэж санал хэлмээр байна.

Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох. Харамсалтай нь өнөөдөр манай дээр тулгамдсан асуудал бол хууль тогтоомж батлагдахдаа Монгол Улсад хөрөнгө оруулаад бас нэг үйлдвэр барьж байгаа, парк байгуулж байгаа нөхдүүдийгээ хүнд байдалд оруулдаг ийм нөхцөл яах аргагүй бидэнд байгаа. НӨАТ-тай холбоотой. Тийм ээ. Маш олон үйлдвэрүүдийн хаалга барьсан. Маш олон Монголд итгэж найдаж төлөвлөгөөгөө гаргаж, олон жил ТЭЗҮ юмаа хийж үйлдвэр барьсан нөхдүүд хохирсон байгаа.

Тэгэхээр цаашдаа тогтоолын төсөл дээр нэгэнт баригдсан, хөрөнгө оруулсан үйлдвэрүүдийг бойжуулах, босгож ирэх тал дээр тодорхой санал заалтуудыг оруулбал их зүгээр байх гэсэн бодолтой байна. Өөрөөр хэлбэл цоо шинийг барьж байгуулах биш, нэгэнт эхэлсэн байгаа, этгээд Монголд хөрөнгөө оруулсан энэ үйлдвэрүүдийг хэрхэн яаж богино хугацаанд босгох вэ гэдэг тал дээр Их Хурлын гишүүд маань хамтарч дэмжиж ажиллах ёстой гэдэг ийм байр

суурьтай байна. Ингэж засахгүйгээр шинэ хөрөнгө оруулалт, шинэ үйлдвэр барих талаар яриад нэмэргүй.

Тийм учраас одоо нэгэнт барьсан байгаа үйлдвэрүүд тоотой хязгаартай, энэ чинь маш тодорхой байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр тохирсон бодлогыг Засгийн газрын тогтоолд тусгайлан заавал яасан юм бэ. Ерөнхий заахаасаа илүү гэдэг ийм саналыг хэлэх гэсэн юм. Асуулт алга байна. Дэмжиж байгаа.

С.Ганбаатар: Буянгийн Тулга гишүүн маш чухал санал орууллаа. Ажилдаа тусгаж авах ёстой.

Ингээд Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Санал байна. Тогтоолын төслийн 2 дээр ашигт малтмалыг дотооддоо боловсруулахыг түлхүү дэмжих зорилгоор төрийн өмчийн ордоос ашигт малтмал худалдан авах, боловсруулахад эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэх гэж байгаа.

Тэгэхээр үүнийг төрийн өмчийн ордоос гэдгийг хасаад ашигт малтмал худалдан авах, боловсруулах эрх зүйн орчин, таатай нөхцөл бүрдүүлэх гэж өөрчлөх саналыг дэвшүүлж байна.

Үндсэн хуулиар өмчийн ялгаварлахгүй аль аль хэлбэр нь байна гэсэн тийм агуулга байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ парк дотор үйлдвэрлэл явуулах гэж байхад түүхий эдийг нь нийлүүлэх саад тотгорыг бууруул гэсэн агуулга энэ дээр байгаа. Тэр түүхий эдийг нийлүүлэхдээ төрийн өмчийн уурхай юм уу, хувийн уурхай юм уу. Ингэх юм бол энэ тийм ялгаварласан суурь концепцын хувьд зөрүүтэй зүйл болж байна гэж үзэж байгаа.

Тийм болохоор төрийн өмчийн ордоос гэдэг гурван үгийг хасаад, ашигт малтмал худалдан авах, боловсруулах эрх зүйн таатай орчин бүрдүүлэх гэдэг саналтай.

Хоёрдугаарт нь, 3 дугаар зүйл дээр нь Үйлдвэр, технологийн паркт ашигт малтмал гүн боловсруулах технологийн, санхүүгийн өндөр чадавхтай этгээдэд шаардлагатай ашигт малтмал хайгуулын тусгай зөвшөөрлийг тусгай нөхцөлтэйгөөр олгох механизм бүрдүүлэх.

Тэгэхээр энэ нөгөө хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журам, магадгүй Ашигт малтмалын хууль дээр, эсвэл тэр журмуудын өөрчлөлт орох тийм үр дагаврыг гарга л гэсэн агуулга байна.

Тэгээд энэ дээр зорилго нь болохоор хөрөнгө оруулагч этгээд үйлдвэр барьчихлаа. Өөртөө хэрэглэх гэж байгаа түүхий эдийн лиценз дээр нь дэмжлэг өгөөч гэсэн агуулга харагдаж байгаа юм. Магадгүй хэрэгтэй байх. Тийм бол үйлдвэрлэл, технологийн паркт хөрөнгө оруулсан гэж нэмэх.

Өөрөөр хэлбэл би хөрөнгө оруулах гэж байгаа гээд гоё цаас үзүүлж байгаад хайгуулын тусгай зөвшөөрлийн юуг хөнгөлөлттэй байдлаар авахгүй л гэсэн үг.

Үйлдвэр, технологийн паркт хөрөнгө оруулсан ашигт малтмал, гүн боловсруулалт, технологийн болон санхүүгийн чадавхын этгээдэд тухайн технологийн паркийн үйл ажиллагаанд шаардлагатай ашигт малтмалын хайгуулын зөвшөөрөл дээр хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох механизмыг бүрдүүлэх гэвэл энэ бол ингээд нөгөө худлаа гоё юм харуулж байгаад явах гэдэг боломжийг нь хаах юм болов уу гэж.

Тэгэхээр мэдээж цаанаа бол нарийн зохицуулалт нь хууль эрх зүй дээрээ очоод явна. Гэхдээ агуулга нь энэ тогтоол дээрээ тодорхой байх нь зөв гэж бодож байна.

С.Ганбаатар: Хариулах уу? Гайгүй биз дээ. Аан..? Болох уу? Та дэмжиж байгаа. Тийм ээ. Б.Уянга гишүүн саналыг бас редакцияар авч болох ийм талтай гэж ойлголоо.

Ингээд миний зүгээс тодруулж асууя даа.

Ер нь энэ дээр Үйлдвэр, технологийн парк гацаанд орсон. Харин ч нэлээн судлаад одоо үүнийг явуулахаар болж байгаа. Явуулъя гээд нэлээн хичээж байгаа. Энэ паркийн төлөө амьдралаа зориулаад хамаг л хөрөнгө мөнгө, нервээ зориулаад явж байгаа хүмүүстэй төр засаг нь нэг ширээн дээр суугаад зөвлөлддөг, ярьдаг, мэдээллээ өгдөг, тэгээд бэрхшээлүүдийг нь бас тэр шийдвэртээ тусгадаг тэр хэлэлцээрийн, ойлголцлын механизм энэ дотор туссан уу, тусаагүй юу. Тэгэхгүй бол төр засаг, сайд дарга нар чинь бол ер нь маш ухаантай улсууд шүү дээ. Зарим нь ч бүр маш ухаантай царайтай.

Тэгэхээр тэд нартай ярилцаж хүнд суртлын гэтлэх механизм энэ дээр тусаж орж чадсан уу? Б.Уянга гишүүн хариулах уу? Энэ дээр.

Б.Уянга: Форумын үеэр гарч ирж байсан саналуудын нэг.

Та форумыг хааж үг хэлэхдээ тэнд цугласан байсан үйлдвэр, технологийн парктай, үйлдвэржилттэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг бүхий л талын төлөөлөгчдөд Та хэд нэг суугаад хоорондоо сард нэг удаа ч юм уу асуудлаа ярьдаг байвал зүгээр гэсэн санал, санаачилга хурлын тэмдэглэлд үлдсэн байгаа.

Тэгээд одоо манай 3 зүйлтэй энэ “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төсөлд яг энэ өгүүлбэрээрээ ороогүй байна. Тэгээд үйлдвэр, технологийн паркийн яг энэ ажлын хэсэг хэсгийн нэгдсэн дүгнэлтэд орохоор тэмдэглэлд туссан агуулга учраас тэмдэглэгдээд яваа.

Гэхдээ та санал гаргаад тэгээд бид хэд бас ажиллаад яг нэг өгүүлбэр байдлаар холбогдох яам буюу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд нь даатгаад оруулах бүрэн боломжтой.

С.Ганбаатар: Тэгвэл их баярлалаа. Энэ дээр редакцаар зүгээр засвар нэгэн тийм тусдаа бие даасан санал би оруулсангүй.

Энэ хоёрдугаар саналын 3-д нь үйлдвэр, технологийн паркийн нэгжид төрөөс үзүүлэх дэмжлэгүүдийг холбогдох санал, дүгнэлтэд тулгуурлан илүү сайжруулж боловсронгуй болгох гэдэг дээр их ерөнхий, хэн ч авч хаяж болохооргүй юм туссан байна.

Тэгэхээр энэ дээр илүү сайжруулах дотор үйлдвэр, технологийн паркийн нэгдсэн холбоогоор нь толгойлуулаад энэ үйлдвэр, технологийн паркийн нэгжүүдийг зохион байгуулалтад оруулж, тэдэнтэй тогтмол хугацаанд уялдаж, харилцан ярьж, хэлэлцээрт ордог байх, хамтын шийдвэр гаргадаг байх энэ механизмыг төлөвшүүлэх гэдгийг би редакцын саналаар Б.Уянга гишүүн зөвшөөрвөл оруулмаар байна.

Урьд нь хэлэлцүүлгийн шатад явж байсан, паркт зүтгэж байсан олон хүмүүсийн гаргасан саналыг би хаяж байгаа юм шүү. Миний санал гэхээс илүү.

Ийм редакцын санал би оруулахыг хүсэж байна.

Ингээд үг хэлэх гишүүд байна уу? Г.Очирбат гишүүнээр үг хэлэхийг тасаллаа. Ингээд Г.Очирбат гишүүн, Д.Үүрийнтуяа гишүүн хоёр үг хэлнэ.

Г.Очирбат: Энэ Үйлдвэр, технологийн парк Монгол Улсад хамгийн чухал асуудал.

Монгол Улсын Их Хурлын гишүүд сайд, дарга нар бүгдээрээ ярихдаа энэ үйлдвэрлэлийн салбарыг дэмжинэ гэж ярьдаг. Уул уурхайн салбараа дэмжинэ гэж ярьдаг. Эдийн засагт хамгийн их ач холбогдолтой байгаа гээд л ярьдаг. Яг бодит амьдрал дээр хийдэггүй.

Тэгээд ямар ч байсан Үйлдвэр, технологийн паркийн форумыг хийгээд бид нараас яг энэ танхимд суусан. Олон асуудлууд гарч ирсэн. Хувийн хэвшлийнхэн оролцсон, мэргэжлийн холбоодууд оролцсон, үйлдвэр, технологийн паркуудын удирдах албан тушаалтнууд оролцсон гээд өргөн хүрээтэй хэлэлцүүлэг болсон.

Тэгээд хэлэлцүүлгийн үр дүн яг л энэ цаасан дээр явж байна л даа. Тэгээд бас үүнийг боловсруулж орж ирсэн би Б.Уянга гишүүндээ бүр баярлалаа гэж хэлэх гэж байгаа юм. Б.Уянга гишүүн энэ дээр манлайлал үзүүлээд ажлын хэсгээ удирдаад энэ ажлын ард гараад өнөөдөр бид “Засгийн газарт чиглэл өгөх” тогтоолын төслөө батлах гээд сууж байгаад нь талархаж байгаа юм.

Тэгээд үүний төлөө цаашаа явах ёстой шүү. Бид ингээд Их Хурлын тогтоолын төсөл боловсруулаад өгнө. Батлагдах уу, батлагдахгүй юу. Батлагдчихаад араас нь ажил болгохын төлөө явах ёстой. Нөгөө татах хүчний асуудал, нэг цонхны асуудал, хүндрэлгүй байлгах асуудал. Яг хөгжүүлэх гээд байвал энэ Үйлдвэр, технологийн паркаараа дамжуулж кластер байдлаар л Монгол Улсын энэ үйлдвэрлэлийн салбар хөгжинө шүү дээ.

Яг одоогоос бараг нэг цагийн өмнө бид энэ жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэлийг ингээд л яриад л энд суулаа. Тэгээд цаашдаа ер нь энэ кластер маягаар үйлдвэрлэлийн салбараа хөгжүүлээд, үүнтэй нь холбоотой тэр Худалдааны тухай хуулийг уяж өгөх. Тэгээд цаашаага дотоодынхоо үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэдэг ийм боломж бололцоо руу нь оруулж өгөхгүй бол одоо бүх юм тархай бутархай. Тийм ээ. Ямар ч байсан нэг хуультай юу, хуультай. Тэр нь бодит амьдрал дээр хэрэгждэггүй нэг ийм юм болоод байгаа.

Тэгэхээр энэ удаагийн Байнгын хорооны боловсруулагдах энэ тогтоолын төсөл нэлээн тийм ач холбогдол өгөх байх гэж бодож байгаа юм.

Зарим нэг санал тэр чигээрээ явсан уу гэдэг асуулт байгаад байдаг. Үүнийг би Б.Уянга гишүүнтэй дахиад ярья даа. Яагаад гэхээр хүн амын орлогын албан татвартай холбоотой асуудал жил нь 5 жил байсан уу, бид 10 жил байсан уу. Дэмжихдээ. Тийм ээ. Зарим нь 8 жил байсан уу, 7 жил байсан уу гэсэн протоколоо нэг дахиад харах ёстой байх.

5 жилийн хугацаанд яг том төсөл, хөтөлбөрүүд босож ирж амжих уу, амжихгүй юу. Тийм ээ. Ингээд юмнууд гарах байх шүү. Тэгээд энэ ажлын хэсгийн санал, дүгнэлтийг дэмжиж өгөөрэй гэж Аж үйлдвэржилтийн байнгын хорооныхоо гишүүдэд хэлэх гэсэн юм. Үнэхээр сайн ажилласан шүү. Тэгээд Б.Уянга гишүүндээ дахин дахин баяр хүргэе. Ажлын хэсгийнхэндээ баяр хүргэе. Би бас өөрөө ажлын хэсэгт нь орж ажилласан.

Тэгээд хэдүүлээ хамтдаа бас энэ тогтоолын төслөө батлуулъя. Д.Үүрийнтуяа гишүүндээ бас баярлалаа.

С.Ганбаатар: Ганбатын Очирбат гишүүн үг хэллээ.

Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн үг хэлнэ.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоол.

Хэдүүлээ нэг зарчмын асуудал дээр бас тохирмоор санагдаад байгаа юм. Засгийн газарт нэг төлөвлөгөө гарга, хөтөлбөр боловсруул гэдэг чиглэлийг бас Их Хурал өгөөд баймааргүй л байгаа юм.

Тэгэхээр редакцын санал байна. Үйлдвэр, технологийн паркт бодлогын дэмжлэг үзүүлэх чиглэл гэдэг зүйл дээр тухайлах юм бол 5 дахь хэсэг. Хамгийн сүүлийн үг, үсгийг нь уншаарай. Боломжит хувилбарыг танилцуулах гээд байгаа юм. Бодлогын дэмжлэг үзүүл гэж үүрэг өгчхөөд боломжит хувилбарыг хэнд танилцуулах вэ гэдгээс л бичиг цаасаа эхлээд хармаар байна.

Ер нь хууль, эрх зүйн орчныг сайжруулах тал дээр Засгийн газарт чиглэл өгмөөр байгаа юм. Яагаад гэхээр Үйлдвэр, технологийн паркийн тухай хууль, Хүнд үйлдвэрийн хууль, Хөнгөн үйлдвэрийн хууль, яг энэ аж үйлдвэрийн салбарын бодлогын эрх зүйн орчныг зохицуулж байгаа хууль, салбарын яамнаас бодлоготойгоор цогцтойгоор, хоорондоо уялдаатай, концепцтой орж ирмээр байгаа юм.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлах эрхтэй. Гэхдээ аль нэг хуулийг нь салгаж аваад хүн хүн санаачлаад явах биш. Яг энэ аж үйлдвэржилтийн салбартай холбоотой асуудлыг салбарын яам нэгтгэж орж ирээд энэ асуудал дээрээ бодлогын зохицуулалт хийгээд явах юм илүү ач холбогдолтой байгаа учраас Үйлдвэр, технологийн паркийн тухай хуульд эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах, Хүнд үйлдвэрийн хууль, Хөнгөн үйлдвэрийн хуулийн анхдагч хуулийн төслийг санаачлах, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг яаралтай дуусгах, мөн дотор нь хуулиар зохицуулж болох заалтуудыг оруулахгүйгээр ийм гол гол хуулийн зохицуулалтуудаараа асуудлыг үүрэг чиглэл өгөөд явбал яасан юм бэ гэсэн зарчмын саналтай байна.

Тэгээд тогтоолын 2 дахь хэсэг буюу хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр гэдгийн 4 дэх заалтыг бас харах хэрэгтэй. Аж ахуйн нэгжүүдэд тавигдах нийтлэг шаардлагаас өндөргүй байх гэхээр хууль зөрчсөн шаардлагыг Үйлдвэр, технологийн паркийн хүрээнд байгаа аж ахуйн нэгжүүдэд тавиад байгаа юм уу гэсэн ойлголт үүсэхээр хүртэл ийм үг, үсэг агуулгын хувьд харагдаад байна л даа.

Тэгэхээр редакцын хувьд нэлээн засаж сайжруулах хэрэгтэй байх. Агуулгын хувьд дэмжиж байна. Г.Очирбат гишүүний саналыг ойлголоо. Дэмжиж байна.

С.Ганбаатар: Д.Үүрийнтуяа гишүүн үг хэллээ.

Ингээд санал хураалтаа эхэлье. Санал хураалтдаа бэлдье. Ингээд хурууныхаа хээг дахин уншуулж байгаа шүү. Санал хураалтад.

Ингээд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

Редакцын засвартайгаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

66.7 хувийн саналаар санал томъёолол дэмжигдлээ.

Ингээд тогтоолын төсөлд Д.Үүрийнтуяа гишүүний саналыг бас тусгаарай. Яагаад гэвэл тогтоолын төсөл заавал хэрэгжих ёстой шүү дээ. Хуультай адилхан хэрэгжих ёстой зүйл шүү. Тэгээд араас нь нэхэл хатуутай явах ёстой шүү. Гишүүд минь.

Ингээд Байнгын хорооны шийдвэрийг үнэлгээг нь өндөрт өргөхийн тулд та нар минь араас нь явах ёстой.

Ингээд ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа. Та бүхэнд өндөр амжилт хүсье.

Ингээд өнөөдрийн М.Бадамсүрэн гишүүн горимын санал гаргах гэж байна шүү. Гишүүд маань байж байгаарай. Үүний дараа нэг цаг 30 минутад яг эндээ хуралдана шүү. Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороотой хуралдана шүү.

М.Бадамсүрэн гишүүний микрофоныг өгье. Горимын санал.

М.Бадамсүрэн: Засгийн газрын чиглэл өгөх тухай үүний урд талын тогтоолын төслийг санал хураалтыг дахин зохион байгуулж өгөөч гэсэн санал гаргаж байна. Тийм.

С.Ганбаатар: Дараагийн хурал дээр оруулах нь та нарын асуудал. Дахиж оруулах нь. Ингээд бас тэгж замбараагүй болохгүй байх.

Ингээд Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүдэд баярлалаа.
/алх цохив/

Хуралдаан 2 цаг 12 минут үргэлжилж, 12 цаг 59 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД